

МУИС-ийн ХЗС-ийн харьяа

“Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв”

**АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Судалгааны баг:

Зөвлөх: Батболдын Амарсанаа

Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн профессор

Зөвлөх: Содномдаваагийн Цолмон

Эдийн засгийн ухааны доктор, Мандах ИС-ийн профессор

Ахлагч: Ганхуягийн Давааням,

Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш

Гишүүн: Энхзоригтын Сэлэнгэ

Эрх зүйн бакалавр, судлаач

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	2
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	3
2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	6
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	10
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	20
2.4. Үр дүнг тооцох	21
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	22
III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	22
3.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох	22
3.2 Зардал тооцох	28
3.3. Тоон үзүүлэлтийг тооцох	31
3.4. Зардлын дүнг тооцож гаргах	32
3.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	34
3.6. Нэмэлт зардлыг тооцох	34
IV. ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО	34
4.1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	35
4.2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох	37
4.3. Тоон үзүүлэлтийг тооцох	38
4.4. Нийт дүнг тооцож гаргах	40
4.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	42
V ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ЗАРДАЛД ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ	43
5.1. Хуулийн этгээдэд үзүүлэх эерэг нөлөөлөл	46
5.2. Иргэнд үзүүлэх эерэг нөлөөлөл	50
5.3 Төрд үзүүлэх эерэг нөлөөлөл	54
VI ДҮГНЭЛТ, САНАЛ	60

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

(АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ)

I. УДИРТГАЛ

Монгол Улс нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш 30 гаруй жилийг ардаа үдэж, хувиараа арилжаа эрхлэгч, нөхөрлөл, компаниас бүрдсэн нийт 90.000 орчим арилжаа эрхлэгчтэй болжээ¹. Энэ хугацаанд арилжаа эрхлэгчийн зохион байгуулалтын хэлбэрийг зохицуулсан 1991 оны Аж ахуйн нэгжийн тухай хууль, 1995 оны Нөхөрлөл компанийн тухай хууль, 1999 оны Компанийн тухай хууль, 2011 оны шинэчлэн найруулсан Компанийн тухай хууль, арилжааны эрхлэгчийн гэрээ хэлцлийн харилцааг зохицуулсан 1994 оны Иргэний хууль, 2002 оны Иргэний хуулийг баталж, хувийн өмч, арилжааны үйл ажиллагаа, түүнд хамаарах суурь ойлголтыг хэвшүүлсэн хэмээн ойлгож болно.

Харин үндэсний хэмжээний томоохон компаниудтай болж, олон улсад худалдаа арилжаанд оролцох болсон өнөө үед Монгол Улсын дотоодын арилжаа эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, эрх зүйн хамгааллыг бэхжүүлэх шаардлагатай тулгарах болсон. Тухайлбал, 19-р зуунд Аж үйлдвэрийн хувьсгалын дараа Франц, Герман, Япон зэрэг улсууд арилжаа эрхлэгчийг төв болгосон Арилжааны хуулийг баталсан бол сүүлийн жилүүдэд Вьетнам, Макао улсууд эдийн засгийн харилцааг дэмжих үүднээс Иргэний хуулиас бие даасан Арилжааны хуулийг батлах болжээ. Бусад улсын туршлагаас үзэхэд Арилжааны хууль нь арилжааны харилцааг түргэн шуурхай, хялбараар зохион байгуулж, үр ашиггүй зардлыг бууруулах замаар арилжаа эрхлэгчийн ашгийн төлөө зорилгыг хангах, хэлцлийн баталгаат байдлыг бэхжүүлэхэд чиглэдэг.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар Арилжааны ерөнхий хуулийн төслийг 21 бүлэг, 137 зүйлтэйгээр боловсруулсан байна. Хууль тогтоомжийн тухай хууль²-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. Үүний дагуу, Арилжааны ерөнхий хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан тооцож, судалгаа хийх хэрэгцээ, шаардлага үүссэн.

Энэхүү судалгаа нь Арилжааны ерөнхий хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал,

¹ Арилжааны хуулийн этгээд буюу нөхөрлөл, компанийн тоо 80.000 орчим байгаа бол хувиараа арилжаа эрхлэгчийн тоог тодорхойлсон статистик байхгүй.

² “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail/11119> (сүүлд үзсэн: 2023.09.09).

ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд чиглэгдэнэ. Энэхүү зардлын тооцооны судалгааг дараах үндсэн бүтцийн дагуу гүйцэтгэв. Үүнд:

1. Хуулийн төсөлд заасан чиг үүрэгтэй холбогдон үүсэх зардал

- 1.1 Төрийн байгууллагын зардлын тооцоо;
- 1.2 Хуулийн этгээдийн зардлын тооцоо;
- 1.3 Иргэний зардлын тооцоо.

Энэхүү хэсэгт гагцхүү нэмэлтээр орсон эсхүл өөрчлөгдсөн чиг үүрэгтэй холбоотой зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөөгүй буюу өмнө нь Иргэний хууль болон бусад дагалдах хууль тогтоомжийн хүрээнд байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно. Тухайлбал, арилжааны хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой зардлыг хамааруулж болно.

2. Хуулийн төсөлд батлагдсанаар зардлын эерэг зардал

- 2.1 Төрд үзүүлэх эерэг нөлөөлөл;
- 2.2 Хуулийн этгээдэд үзүүлэх эерэг нөлөөлөл;
- 2.3 Иргэнд үзүүлэх эерэг нөлөөлөл.

Энэ хэсэгт одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой холбоотойгоор төр, иргэн, хуулийн этгээдийн зүгээс гэрээ хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах, гэрээний гүйцэтгэлийг хангуулах зорилгоор практикт зайлшгүй хийгдэж буй стандарт үйл ажиллагааг тодорхойлон түүний зардлыг тооцож, Арилжааны ерөнхий хуулийн төсөл батлагдсанаар дээрх зардал буурна гэж үзлээ.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардал болон төсөл батлагдсанаар буурах зардлыг тус тус тооцож, үр дүн үндэслэн хуулийн төслийн зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандартыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох дараах зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 8.1.Хувиараа арилжаа эрхлэгчийн өмнөх санхүүгийн жилийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ, эсхүл арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг санхүүгийн жил өнгөрөөгүй байгаа тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлэх үеийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур байвал түүнийг жижиг арилжаа эрхлэгч гэж үзнэ.
- 9.5.Арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгэгдэх мэдээллийн төрөл, нээлттэй болон хаалттай байх мэдээллийн агуулга, бүртгэл хөтлөх журмыг холбогдох хуулиар зохицуулна.

Хуулийн төслийн дараах зохицуулалт нь түүний хэрэгжилттэй холбоотойгоор шүүхийн нэхэмжлэл, шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй боловч тохиолдлын тоо, давтамжийг урьдаас тогтоох боломжгүй. Иймээс аргачлалын 4.3.3 дахь хэсэгт “ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулна”, 4.3.2 дахь хэсэгт “байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно” гэж заасныг үндэслэж шүүхийн ачааллыг тооцоогүй болно. Үүнд:

- 12.2.Арилжаа эрхлэгч арилжааны нэрийг нь энэ хуулийн 12.1-д заасныг зөрчиж ашигласан этгээдийн эсрэг уг үйлдлийг таслан зогсоох, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Хохирол нөхөн төлүүлэхээр шаардах тохиолдолд Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ.

Арилжааны ерөнхий хууль дахь төрийн байгууллагын үүрэгт холбогдох дараах зүйл, заалтыг (Хүснэгт 1-т заасан) хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцлоо.

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Төрийн байгууллага	Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Арилжааны ерөнхий хуулийн төслийн дараах зүйл, заалт: ▪ 9.1.Арилжааны бүртгэл нь <u>хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл</u> болон ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бүрдэнэ.	Арилжааны ерөнхий хуулийн төслийн дараах зүйл, заалт: ▪ 6.4 Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн энэ хуулийн 6.2-т заасан арилжааны үйл ажиллагааг эрхлэн явуулж эхэлсэн үеэс хувиараа арилжаа эрхлэгч болно.

	9.3.Бүртгэлийн байгууллага арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд шинээр бүртгүүлсэн болон хасагдсан, бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай нийтэд мэдээлнэ. 10.1.Арилжааны бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр арилжаа эрхлэгч зохих өөрчлөлтийг арилжааны бүртгэлд тусгуулж, арилжааны бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй. Арилжааны бүртгэлд холбогдох өөрчлөлтөө тусгуулаагүйгээс гарах үр дагаврыг арилжаа эрхлэгч хариуцна. 13.3.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бичгээр байгуулж, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг зөрчсөн гэрээ хүчин төгөлдөр бус байна. 13.8.Энэ хуулийн 13.7-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсны дараа даруй тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авахаас өмнө үүссэн үүргийг хариуцахгүй болохоо арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол тухайн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээхгүй.	6.7.Энэ хуулийн 6.4-т заасан арилжаа эрхлэгч нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлээгүй нь түүнийг арилжаа эрхлэгч биш гэж үзэх үндэслэл болохгүй. 6.6.Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны хувь хүн энэ хуулийн 6.2-т заасан арилжааны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд уг үйл ажиллагааг эрхлэн явуулж эхлэхээсээ өмнө хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулж зохих журмын дагуу арилжааны бүртгэлд бүртгүүлнэ. 7.1.Энэ хуулийн 6.2-т заасан шинжийг хангаагүй үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн нь энэ хуульд заасан арилжааны бүртгэлд сайн дураар бүртгүүлж арилжаа эрхлэгч болж болно. 7.5.Жижиг арилжаа эрхлэгч нь арилжааны бүртгэлд сайн дураараа бүртгүүлж болно. 9.2.Хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн харилцааг хуулиар зохицуулна. 9.4.Арилжааны бүртгэл дэх арилжаа эрхлэгчийн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх болон хаалттай байх мэдээллээс бүрдэнэ. 9.5.Арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгэгдэх мэдээллийн төрөл, нээлттэй болон хаалттай байх мэдээллийн агуулга, бүртгэл
--	---	---

	14.6.Энэ хуулийн 14.2-т заасан арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь бусдад олгосон, эсхүл дуусгавар болгосон бол энэ талаар арилжааны бүртгэлд тухай бүр бүртгүүлэх үүрэгтэй.	хөтлөх журмыг холбогдох хуулиар зохицуулна. 9.6.Хувиараа арилжаа эрхлэгч дахин давтагдашгүй бүртгэлийн дугаартай байна. Энэ хуулийн 12 дугаар зүйлийг тус бүртгэлийн дугаарын хувьд нэгэн адил хэрэглэнэ. 9.7.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол бүртгэгдсэн болохыг илэрхийлсэн “Х.А.Э” буюу хувиараа арилжаа эрхлэгч гэсэн ялгах тэмдгийг арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа хэрэглэнэ. 11.1.Арилжаа эрхлэгч нь хэлцэл хийх, арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа өөрийн арилжааны нэрийг хэрэглэнэ. Арилжааны нэр нь арилжаа эрхлэгч нэхэмжлэл гаргах, хариуцагчаар татагдах тохиолдолд хэрэглэгдэж болно. 11.2.Хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ бүртгүүлж болно. 11.3.Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн арилжааны нэр байна.
--	--	---

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Хэрэгжүүлэх, хэмжих боломжтой чиг үүргийг хамруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов. Ингэхдээ:

1. Төслийн 6.3 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд компани, нөхөрлөл хэлбэрээр бүртгүүлж байгуулагдсанаар арилжаа эрхлэгч болно” гэж, 11.3 дахь хэсэгт “Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн арилжааны нэр байна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ашгийн төлөө хуулийн этгээд анх байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн цагаас эхлэн арилжаа эрхлэгч болно. Иймд **арилжааны хуулийн этгээдийг бүртгэх нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1 дэх хэсэг дэх Улсын бүртгэлийн ерөнхий газрын чиг үүрэгт хамаарах тул нэмэлт зардал гарахгүй гэж үзлээ.** Харин хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэл шинээр бий болох нь гарцаагүй ба уг бүртгэлд жижиг болон бусад хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэх, мэдээлэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, цаашлаад бүх төрлийн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх чиг үүрэг шинээр үүсэх тул түүнд холбогдох зардлын тооцоог тооцоолов.
2. Аргачлалын 4.4.2 дахь хэсэгт “зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэж заасныг үндэслэн Хууль зүйн сайдын 2015 оны А39 дүгээр тушаалын хавсралт “Хуулийн этгээдийн улсын бүртгэл бүртгэх журам”-г харгалзан үзэж тогтоолоо.

Өмнө нь дурдсанчлан хуулийн төсөл батлагдсанаар төрд үүсэх зардлын тооцохдоо төрийн байгууллагын одоо гүйцэтгэж байгаа чиг үүргийг давхардуулан тооцоогүй. Тухайлбал, арилжааны хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой чиг үүрэгтэй холбоотой нэмэлт зардал төрд үүсэхгүй. Арилжааны ерөнхий хуулийн дагуу арилжааны бүртгэл сонгодог утгаар хөгжих бөгөөд хувиараа арилжаа эрхлэгч ч мөн бүртгэлд бүртгүүлэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл, арилжаа эрхлэгч хувь хүний арилжаа бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, тэдгээрийг мэдээлэх, цаашлаад арилжааны нэрийн шилжилтийг бүртгэх зэрэг чиг үүргийг аливаа байгууллага гүйцэтгэх шаардлага үүснэ.

Шигтгээ 1:

АРИЛЖААНЫ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ БУЮУ НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙГ БҮРТГЭХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ ЗАРДАЛ ТӨРД ҮҮСЭХГҮЙ.

Бусад улсын туршлагыг авч үзвэл, арилжааны бүртгэлийг гагцхүү төрийн байгууллага бус хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Нидерланд болон Итали зэрэг улсад уг чиг үүргийг Худалдаа аж үйлдвэрийн танхим хэрэгжүүлдэг.

Шигтгээ 2:

АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙГ БҮРТГЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХУУЛИАР НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД/ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ/-ЭД ШИЛЖҮҮЛЭХ ЗАМААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДАЛ, АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ.

Монгол Улсын хувьд хуулийн этгээдийн бүртгэлийг улсын бүртгэлийн газраас хэрэгжүүлдэг тул нэгдсэн байдлыг хангаж арилжааны бүртгэлийг тухайн байгууллага хариуцна гэж үзэж холбогдох зардлыг тооцлоо. Гэвч арилжааны бүртгэлийг Худалдаа аж үйлдвэрийн танхим хэрэгжүүлэх хувилбарыг нэвтрүүлэх боломж байхыг үгүйсгэхгүй бөгөөд энэ тохиолдолд төрд зардал үүсэхгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Төрийн байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэл бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, нийтэд мэдээлэх ³	Улсын бүртгэгч хүсэлтийн дагуу нэрийн баталгаажуулалт хийх
		Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах

³ Үүнд жижиг арилжаа эрхлэгч мөн хамаарна. Төслийн 8.1 дэх хэсэгт “Хувиараа арилжаа эрхлэгчийн өмнөх санхүүгийн жилийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ, эсхүл арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг санхүүгийн жил өнгөрөөгүй байгаа тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлэх үеийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур байвал түүнийг жижиг арилжаа эрхлэгч гэж үзнэ.” Гэж заасан.

		Арилжааны бүртгэлд бүртгэх шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийг цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлийн дугаар олгох
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх
		Арилжааны бүртгэлд бүртгэл үүсгэсэн эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах
		Арилжааны бүртгэлд бүртгэл үүсгэсэн эсэх талаар нийтэд мэдээлэх
	Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг шийдвэрлэх, нийтэд мэдээлэх	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах
		Арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх
		Арилжааны бүртгэлд өөрчлөлт оруулсан эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах
		Арилжааны бүртгэлд өөрчлөлт оруулсан эсэх талаар нийтэд мэдээлэх
	Хувиараа арилжаа эрхлэгчийг арилжааны бүртгэлээс хасуулах	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх

	хүсэлтийг шийдвэрлэх, нийтэд мэдээлэх	Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах
		Арилжааны бүртгэлээс хасах шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх
		Арилжааны бүртгэлээс хассан эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах
		Арилжааны бүртгэлээс хассан эсэх талаар нийтэд мэдээлэх
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бүртгэх, нийтэд мэдээлэх	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах
		Арилжааны нэрийн шилжилтийг бүртгэх шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн нэрийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх
		Арилжааны нэрийн шилжилтийг бүртгэсэн эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах
		Арилжааны нэрийн шилжилтийг нийтэд мэдээлэх

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистик тоон мэдээллийг ашиглан тооцсон бөгөөд бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтоов.

Тохиолдлын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй гэж 2 ангилна. Үүнд:

1. статистикийн мэдээлэл, түүнчлэн судалгаагаар тогтоож болох ажил, үйлчилгээг тогтоох боломжтой тохиолдлын тоонд хамааруулна;
2. үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна.

Хувиараа арилжаа эрхлэгчдийн тоо

Статистикийн ерөнхий хорооноос 2013-2024 он хүртэл “Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо”⁴-г улирал бүрээр гаргасан байх боловч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг тоолоогүй байна. Харин Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогод 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 53.9 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдсан.⁵ 2021 онд хувиараа арилжаа эрхлэгчийн нийт тоо 53.9 мянга байсан тул өмнөх жилүүдийн өсөлтийн хурдыг⁶ баримталбал 2024 онд уг тоо өсөж 65.0 мянгад хүрсэнд тооцож болно. Гэвч дээр заасан бүх хувиараа арилжаа эрхлэгчид арилжааны бүртгэлд бүртгүүлэхгүй тул арилжааны бүртгэлд бүртгүүлэх тохиолдлын тоог тодорхойлох шаардлага үүснэ.

Хувиараа арилжаа эрхлэгч арилжаа бүртгэлд бүртгүүлэх тохиолдлын тоо

Хүснэгт 3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн статистик тоон мэдээг авч үзвэл:⁷

	2020	2021	2022	2023
Хуулийн этгээдийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн тоо	14030	15767	17774	17445
Компани	11597	13522	13706	13779
Нөхөрлөл	280	231	243	205

⁴ Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, (https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2600_009V1).

⁵ Монгол Улс - Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого, ААНБ 2021, (<http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/340>).

⁶ 2021 онд нийт компанийн тоо 63492 байсан бол 2022 онд 76230 болж 20 хувиар, 2023 онд 79971 болж өмнөх оныхоос 5 хувиар тус тус өсчээ. Харин 2021 онд нөхөрлөлийн тоо 1431 байсан бол 2023 оныд 1650 болж 15 хувийн өсөлт үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл 2021 оноос хойш компанийн тоо 25 хувиар, нөхөрлөлийн тоо 15 хувиар тус тус өсчээ. Иймд 2021 онд бүртгэгдсэн хувиараа арилжаа эрхлэгчдийн тоо 2024 он гэхэд 20 хувийн өсөлт үзүүлсэн гэж тооцож, 65000 гэж тооцлоо.

⁷ 2021 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/59873>.

2022 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/62379>.

2023 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/64309>.

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, улирал, хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр

Статистик үзүүлэлт	Бизнес төрөл	2020-IV	2021-IV	2022-IV	2023-IV
Бүгд	Бүгд	76329	81533	91811	96815
	Компани	59954	63492	76230	79971
	Нөхөрлөл	1532	1431	1570	1650

2020 онд 11.5 мянга, 2021 онд 13.5 мянга, 2022 онд 13.7 мянга, 2024 онд 13.7 мянга компани шинээр бүртгэгдсэн байх ба жилд дунджаар 13.1 мянга компани Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүсэлт гарган, шинээр бүртгүүлсэн.

Хүснэгт 5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн болон нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдлын харьцаа:⁸

	2020	2021	2022	2023
Хуулийн этгээдийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн тоо	14030	15767	17774	17445
Хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулсан тоо	31330	25714	31802	27530
Харьцаа	1:2.2	1:1.6	1:1.8	1:1.6

Хүснэгт 5-г үзвэл хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдлын тоо хуулийн этгээдийн бүртгэлд шинээр бүртгүүлэх тохиолдлоос их байдаг байх ба дунджаар 1.8 дахин их байна.

Хүснэгт 6. Шинээр бүртгүүлсэн тохиолдол ба бүртгэлээс хасуулсан тохиолдол:⁹

	2020	2021	2022	2023
Хуулийн этгээдийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн тоо	14030	15767	17774	17445

⁸ 2021 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/59873>.

2022 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/62379>.

2023 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/64309>.

⁹ 2021 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/59873>.

2022 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/62379>.

2023 оны статистик мэдээ, <https://burtgel.gov.mn/post/64309>.

Хуулийн этгээдийг бүртгэлээс хассан тоо	757	432	610	34974
Хувь	0.05	0.02	0.03	-

Компанийн хувьд, бүртгэлээс хасуулах тохиолдол нь дунджаар шинээр бүртгүүлсэн тохиолдлын тооны 0.03 хувьтай тэнцүү байна.

Гэвч арилжааны бүртгэлд хувиараа арилжаа эрхлэгчээр бүртгүүлэх жилийн дундаж тоог урьдаас таамаглах боломжгүй байгаа тул аргачлалд зааснаар 1 гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэх, түүний бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахад төрд үүсэх нэг удаагийн зардлыг тооцлоо.

Арилжааны нэрийг шилжүүлэх тохиолдлын тоо

Хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийн 1/10 нь нэрийн өөрчлөлттэй холбоотой байдаг. Арилжааны нэрийн шилжилт, хөдөлгөөнийг бүртгэх тохиолдлын тоог урьдаас таамаглах боломжгүй байх тул 1 гэж үзлээ. Өөрөөр хэлбэл нэг удаагийн хүсэлтийг хүлээн авч бүртгэхэд зарцуулах хугацаа, зардлын тооцов.

Хүснэгт 7. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Төрийн байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, нийтэд мэдээлэх	Улсын бүртгэгч хүсэлтийн дагуу нэрийн баталгаажуулалт хийх	10	1	10
		Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах	10	1	10
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх	5	1	5
		Хүсэлтийг хүлээн авсан	5	1	5

		тухай баримт үйлдэж, өгөх			
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах	10	1	10
		Арилжааны бүртгэлд бүртгэх шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах	60	1	60
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийг цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлийн дугаар олгох	30	1	30
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх	15	1	15
		Арилжааны бүртгэлд бүртгэл үүсгэсэн эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах	5	1	5
		Арилжааны бүртгэлд бүртгэл үүсгэсэн эсэх талаар нийтэд мэдээлэх	5	1	5

Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, нийтэд мэдээлэхэд зарцуулах хугацаа				155 минут
Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг шийдвэрлэх, нийтэд мэдээлэх	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах	10	1	10
	Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх	5	1	5
	Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх	5	1	5
	Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах	10	1	10
	Арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах	60	1	60
	Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах	30	1	30
	Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг	15	1	15

		архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх			
		Арилжааны бүртгэлд өөрчлөлт оруулсан эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах	5	1	5
		Арилжааны бүртгэлд өөрчлөлт оруулсан эсэх талаар нийтэд мэдээлэх	5	1	5
	Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг шийдвэрлэх, нийтэд мэдээлэхэд зарцуулах хугацаа				145 минут
	Хувиараа арилжаа эрхлэгчийг арилжааны бүртгэлээс хасуулах хүсэлтийг шийдвэрлэх, нийтэд мэдээлэх	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах	10	1	10
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаар бүртгэх	5	1	5
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх	5	1	5
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах	10	1	10
		Арилжааны бүртгэлээс хасах	60	1	60

		шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах			
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн мэдээллийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах	30	1	30
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх	15	1	15
		Арилжааны бүртгэлээс хассан эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах	5	1	5
		Арилжааны бүртгэлээс хассан эсэх талаар нийтэд мэдээлэх	5	1	5
	Хувиараа арилжаа эрхлэгчийг арилжааны бүртгэлээс хасуулах хүсэлтийг бүртгэхэд зарцуулах хугацаа				145 минут
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бүртгэх, нийтэд мэдээлэх	Ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянах	10	1	10
		Хүсэлт, холбогдох баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд	5	1	5

		хүлээн авснаар бүртгэх			
		Хүсэлтийг хүлээн авсан тухай баримт үйлдэж, өгөх	5	1	5
		Хүсэлтийг улсын бүртгэгчид хуваарилах	10	1	10
		Арилжааны нэрийн шилжилтийг бүртгэх шийдвэр гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах	60	1	60
		Улсын бүртгэгч арилжаа эрхлэгчийн нэрийн өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулах	30	1	30
		Хүсэлт, бүрдүүлэх баримт бичгийг архивлан хадгалах, цахим системд бүртгэх, бүртгэл хөтлөх	15	1	15
		Арилжааны нэрийн шилжилтийг бүртгэсэн эсэх шийдвэрийг хүсэлт гаргагчид гардуулах	5	1	5
		Арилжааны нэрийн	5	1	5

		шилжилтийг нийтэд мэдээлэх			
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бүртгэх, нийтэд мэдээлэхэд зарцуулах хугацаа				145 минут
Нийт					590 минут

Арилжааны ерөнхий хуулийн төслийн хэрэгжилттэй холбоотойгоор хувиараа арилжаа эрхлэгчийг арилжаа бүртгэлд бүртгүүлэх 1 хүсэлтийг шийдвэрлэхэд 155 минут, тус бүртгэлд өөрчлөлт оруулах 1 хүсэлтийг шийдвэрлэхэд 145 минут, арилжааны бүртгэлээс хасахад 145 минут, арилжаа эрхлэгчдийн нэрийн шилжилтийг бүртгэх 1 хүсэлтийг шийдвэрлэхэд 145 минут зарцуулах юм.

Дээр заасан хүсэлт бүрийн жилийн тохиолдлын тоог 2 өөр хувилбараар авч үзэхэд дараах хүний нөөцийн ачаалал үүсэхээр байна.

Хүснэгт. Хувилбарыг тооцох

		1 удаагийн хүсэлт шийдвэрлэх хугацаа	Хувилбар 1		Хувилбар 2	
			Тохиолдлын тоо	Хүн/цаг	Тохиолдлын тоо	Хүн/цаг
1	Хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэх	155	1000	155000	5000	775000
2	Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэл өөрчлөлт оруулах	145	1800	261000	9000	1305000
3	Хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэлээс хасах	145	30	4350	150	21750
4	Арилжааны нэрийн шилжилтийг бүртгэх	145	180	26100	900	130500

Нийт хүн/цаг		446450	2232250
--------------	--	--------	---------

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 8. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Хувилбар 1	446450	96000	4.7
Хувилбар 2	2232250	96000	23.3

2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг эхэлж тооцно.

Төрийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Нэгж зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна. Улсын бүртгэгч нь Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт дахь ТЗ6-ТЗ9-т хамаарч байна. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар үндсэн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТЗ-1	2,440,000
ТЗ-2	2,171,000
ТЗ-3	2,048,000
ТЗ-4	1,933,000

T3-5	1,757,000
T3-6	1,597,000
T3-7	1,452,000
T3-8	1,320,000
T3-9	1,210,000
T3-10	1,100,000

2024 оны 05 дугаар сарын байдлаар, нэг улсын бүртгэгчийн үндсэн цалингийн дундаж хэмжээ 1,394,750 төгрөг байх бөгөөд түүнд оногдох ажил олгогчийн НДШ-ийн зардал 174,343.7 төгрөг байна. Хоол, унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг, дэвийн нэмэгдэл зэргийг шууд тооцоолох боломжгүй тул үндсэн цалингийн хэмжээгээр цалингийн зардлыг тооцов.

Хүснэгт 9. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Хувилбар 1	4.7	18,829,125	87,565,238.09
Хувилбар 2	23.3	18,829,125	437,826,190.43

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал болон холбогдох бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

“Материаллаг зардал” гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 10. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	200,000
Нэг албан хаагчид оногдох		3,840,923

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 11. Нийт зардал

	Хүний нөөцийн зардал	Материаллаг	Нийт
Хувилбар 1	87,565,238.09	17,862,292.43	105,427,530.52
Хувилбар 2	437,826,190.43	89,311,462.15	527,137,652.58

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Арилжааны бүртгэлийн бүрэн гүйцэт, үнэн зөв байдлыг хангах үүднээс тохиолдлын тоог багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй.

2.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх тул давтамжийг багасгах чиглэл баримтлах зохимжгүй.

2.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төсөлд арилжааны бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг тусгаагүй байх тул зарцуулах хугацааг харьцангуй багаар тооцсон.

2.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Одоогоор E-mongolia цахим системийг ашиглан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийлгэх хүсэлтийг цахимаар өгч, цахимаар шийдвэрлэх боломжтой байна. Гэвч хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг цахимаар бус холбогдох сум, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, нэг цэгийн үйлчилгээний газарт биечлэн очих замаар өгч байна. Иймд хуулийн этгээдийн бүртгэл, арилжааны бүртгэлд бүртгүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх тохиолдлыг бүртгүүлэхдээ цахимаар хүсэлт өгөх, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх нь төрд учрах зардлыг бууруулаад зогсохгүй цаашлаад хуулийн этгээд, хувиараа арилжаа эрхлэгчид үзүүлэх ачааллыг бууруулна.

2.5.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог хамгийн багаар тогтоосон байх тул дахин багасгах боломжгүй гэж үзэв.

III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, хуулийн этгээдийн зардалд нөлөөлөх зүйл заалтыг хүснэгт 13-т, зардал нөлөөлөхгүй бусад нэмэлт, өөрчлөлтийг хүснэгт 12-т тус тус харуулав.

Төслийн 6.3 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд компани, нөхөрлөл хэлбэрээр бүртгүүлж байгуулагдсанаар арилжаа эрхлэгч болно” гэж, 11.3 дахь хэсэгт “Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн арилжааны нэр байна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ашгийн төлөө хуулийн этгээд анх байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн цагаас эхлэн арилжаа эрхлэгчийн бүртгэлд мөн бүртгэгдэнэ. Иймд арилжаа эрхлэгч хуулийн этгээдийг бүртгэх нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах тул дараах заалтыг хэрэгжүүлэхэд нэмэлт зардал гарахгүй гэж үзлээ. Үүнд:

- 6.3.Хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд компани, нөхөрлөл хэлбэрээр бүртгүүлж байгуулагдсанаар арилжаа эрхлэгч болно.
- 6.12.Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэг хүлээнэ.
- 10.1.Арилжааны бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр арилжаа эрхлэгч зохих өөрчлөлтийг арилжааны бүртгэлд тусгуулж, арилжааны бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй.
- 11.3.Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн арилжааны нэр байна.

Түүнчлэн, Иргэний хуулийн тусгай анги дахь арилжааны гэрээний тусгай төрлүүдийг Арилжааны ерөнхий хуульд тусгахдаа хэд хэдэн өөрчлөлт хийсэн байх бөгөөд гэрээний талуудын эрх, зарчимтай холбоотой өөрчлөлтөд холбогдох зардлыг тооцоогүй болно.

Цаашлаад гэрээний үүрэг нь диспозитив шинжтэйгээс гадна талууд харилцан тохиролцсоноор өөрчлөх боломжтой. Мөн Иргэний хууль дахь үүргийн зохицуулалтын илүү задалж тодорхой болгосон байна. Иймд императив зохицуулалт биш байх тул дараах өөрчлөлтүүдийг (хүснэгт 12-т заасан) энэхүү зардлын тооцооноос хаслаа. Үүнд:

Хүснэгт 12. Зардалд тооцоогүй үүрэг

	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг /диспозитив шинжтэй/
Арилжаа эрхлэгч хуулийн этгээд	17.1.Үйлчлүүлэгч нь дараах үүрэгтэй байна: 17.1.1.барааны дээж, зураг, танилцуулга, үнийн жагсаалт, зар сурталчилгааны материал, гэрээний нөхцөл, шаардлагатай мэдээлэл зэрэг арилжааны төлөөлөгч өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлийг ашиглах боломжоор хангах; 17.1.2.арилжааны төлөөлөгчийн зуучилсан хэлцэл, эсхүл хэлцэл байгуулахад төлөөлөх бүрэн эрхгүйгээр байгуулсан хэлцлийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх талаар даруй мэдэгдэх; 21.7.Арилжааны төлөөлөгчийн гэрээний нэг тал нөгөө талын буруугаас шалтгаалан гэрээг цуцалсан бол тухайн гэрээг

	цуцалснаас хойш нэг сарын дотор арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийн тохиролцоог цуцлах талаар нөгөө талд бичгээр мэдэгдсэнээр үл өрсөлдөх үүрэг дуусгавар болно. 32.1.Арилжаа эрхлэгч нь өөрийн арилжааны үйл ажиллагааны хүрээнд гэрээ байгуулах саналыг бараатай хамт хүлээн авсан боловч тухайн гэрээний саналд татгалзсан хариу өгсөн бол санал гаргагчийн зардлаар тухайн барааг хадгална.
Арилжааны төлөөлөгч	16.1.Арилжааны төлөөлөгч нь дараах үүрэгтэй байна: 16.1.1.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй; ▪ 16.1.3.арилжааны төлөөлөгчийн хувьд ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажиллах; ▪ 16.1.4.арилжааны төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн, өөрт нь ил болсон үйлчлүүлэгчийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах үүрэгтэй; ▪ 16.1.5.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны төлөөлөгч улирал бүрийн сүүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс зэрэг мэдээлэл бүхий тайланг үйлчлүүлэгчид хүргүүлэх.
Арилжааны зуучлагч	▪ 22.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэлцэл байгуулагдсаны дараа зуучлагч нь гэрээний талуудад хэлцлийн зүйл, нөхцөл, оролцогч тал, бараа, үнэт цаас худалдах худалдан авах гэрээ байсан бол тэдгээрийн төрөл, тоо, хэмжээ, гэрээний үнэ, хугацаа зэргийг тусгасан баримтыг гарын үсэг зурж олгоно. ▪ 22.4.Хиймэгц биелэгдэхээс бусад хэлцэлд энэ хуулийн 22.3-т заасан баримт бичигт хэлцлийн талууд гарын үсэг зурна. Тус гарын үсэг зурсан баримтыг хэлцлийн талуудад тус бүр илгээнэ. ▪ 22.5.Хэрэв хэлцлийн нэг тал баримтад гарын үсэг зурахаас, эсхүл түүнийг хүлээн авахаас татгалзвал арилжааны зуучлагч нөгөө талд энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. ▪ 23.2.Арилжааны зуучлагч нь зуучлагчийн баримтад нэрлэн заагаагүй талыг тухайн нутаг дэвсгэрийн арилжааны заншилд үндэслэн тогтоосон хугацаанд нэрлэн заах үүрэгтэй. Ийм хугацаа байхгүй тохиолдолд зуучлагч тухайн холбогдох нөхцөлд байдалд тохирсон ердийн боломжит хугацаанд баримтад тусгах үүрэгтэй. ▪ 23.3.Арилжааны зуучлагч нь 23.2-т заасан хугацаанд нэрлэн заагаагүй талыг нөгөө талд нь илэрхий болгоогүй, эсхүл нэрлэгдсэн этгээдийн эсрэг гомдол гаргах зохих үндэслэл байгаа бол нөгөө тал нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг арилжааны зуучлагчаас шаардах эрхтэй. Хэлцлийн талууд нь арилжааны зуучлагчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш үүргийн гүйцэтгэлийг арилжааны зуучлагчаас шаардах эрхээ

	хэрэгжүүлэх эсэхээ даруй илэрхийлээгүй бол уг шаардах эрхээ алдана. 24.1.Дээж авах замаар барааг худалдаж байгаа тохиолдолд хэлцлийн талууд тухайн үүргээс зуучлагчийг чөлөөлсөн, эсхүл тухайн хэлцлийн зүйл болох эд юмсын шинж чанараас хамааран тухайн нутаг дэвсгэрийн арилжааны заншлын дагуу зуучлагчийг үүргээс чөлөөлөхөөс бусад тохиолдолд арилжааны зуучлагч нь барааны дээжид тусгай тэмдэг тавих, худалдан авагч барааны чанарт гомдол гаргалгүйгээр хүлээж авах хүртэл дээжийг хадгалах үүрэгтэй. 28.2.Арилжааны зуучлагч гэрээний талуудын шаардсан үед тэмдэглэлээс зуучлалын тусламжтайгаар байгуулсан хэлцлийн тухай мэдээллийг агуулсан өөрийн гарын үсэгтэй баримтыг олгох үүрэгтэй. 28.3.Арилжааны зуучлагч нь 28.1-д заасан шаардлагыг хангасан тэмдэглэлээ цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдсэн эсэхээс үл хамааран 10 жил хадгалах үүргийг хүлээнэ.
Комисс	62.1.Комисс нь дараах үүрэгтэй байна: 62.1.2.комисс нь үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөх, гэрээ хэлцэл байгуулсан бол даруй мэдэгдэх; 62.1.3.комисс нь олсон орлого болон худалдаж авсан барааны өмчлөх эрхийг үйлчлүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй. Гэрээнд өөрөөр заагаагүй бол комисс нь энэ үүргээ сар бүрийн эцэст гүйцэтгэнэ; 62.1.4.комисс нь гэрээ, хэлцэл байгуулсан мэдэгдэлтэй нэгэн зэрэг тухайн байгуулсан гэрээ хэлцлийн нөгөө тал болох гуравдагч этгээдийг нэрлэн заагаагүй бол үйлчлүүлэгчийн өмнө тухайн гэрээ хэлцлийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой хариуцлага хүлээх. 62.1.5.комисс нь үйлчлүүлэгчийн зааварт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулаагүйгээс түүнд хохирол учруулсан бол учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд комиссын байгуулсан гэрээ, хэлцлийг үйлчлүүлэгчийн зардлаар байгуулсанд тооцохгүй. Иргэний хуулийн 400.2-т заасан тохиолдол үүнд хамаарахгүй. 62.2.Комисс нь барааг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд түүнд энэ тухай даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч даруй хариу өгөөгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно. Барааг илүү ашигтайгаар худалдсан тохиолдолд олсон ашгийг үйлчлүүлэгч хүртэнэ.

Илгээгч компани	78.1.Илгээгч нь дараах үүрэгтэй байна: 78.1.1.илгээмжийн гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангахуйц байдлаар тээврийн хэрэгсэл болон тээвэрлэх замыг шийдэх; 78.1.2.тээвэрлэлтэд оролцох этгээдийг (тээвэрлэгчийг) сонгох, түүнд мэдээлэл болон зааварчилгаа өгөх; 78.1.3.илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын, илгээмжийн гэрээг байгуулах; 78.1.4.захиалагчид хохирол шаардах эрхийг шилжүүлэх; 78.1.5.захиалагчийн ашиг сонирхлын дагуу түүний өгсөн даалгаврыг биелүүлэх; 80.2.Илгээгч хяналтдаа байгаа илгээмж алдагдсан, дутсан, гэмтсэний хариуцлагыг хүлээнэ. Үүнээс бусад хохирлыг илгээгч нь энэ хуулийн 78.1-д заасан үүргээ зөрчсөн нөхцөлд хариуцна. Илгээгч нь ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажилласан ч энэ хохирол учрахаар байсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.
Зорчигч тээвэрлэгч	89.3.Тээвэрлэгч нь зорчигчийн хүлээлгэн өгсөн тээшний хувьд уг тээшийг тээвэрлэхтэй холбогдуулан нэмэлт хөлс авах эсэхээс үл хамааран ачаа тээвэрлэлтийн гэрээний тээвэрлэгчтэй адил хариуцлага хүлээнэ. 89.7.Тээвэрлэгч санаатай, эсхүл болгоомжгүй үйл ажиллагааныхаа улмаас хугацаа хоцроосон бол бусдад учруулсан хохирлыг хариуцна.
Тээвэрлүүлэгч	93.11.Тээвэрлэх ачаа нь шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай ачаа байгаа тохиолдолд ачаа илгээгч нь энэ талаар болон ачааны нэр төрөл, шинж чанар болон тухайн ачааг аюулгүй тээвэрлэхтэй холбоотой мэдээллийг ачааг хүлээлгэж өгөхөөс өмнө тээвэрлэгчид өгөх үүрэгтэй.
Барааны агуулахын үйлчилгээ үзүүлэгч	106.3 Хадгалагч нь ердийн боломжит хугацаанд зааварчилгааг хүлээн авч чадаагүй бол эрх бүхий этгээдийн ашиг сонирхолд илүү нийцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Хадгалагдаж байгаа эд хөрөнгө нь өөрийн үнэ цэнийг алдахуйцаар гэмтэж өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн бол хадгалагч нь эрх бүхий этгээдийн зааварчилгааг хүлээлгүйгээр худалдан борлуулах шийдвэрийг гаргаж болно. 106.5.Хадгалагч нь хадгалуулагч болон агуулахын баримт эзэмшигчид барааны агуулах ажиллах ажлын цагаар барааг шалгах, дээж авах, шаардлагатай арга хэмжээ авах боломжоор хангана. Хадгалагч мөн барааг хадгалахад шаардлагатай арга хэмжээ авах эрхтэй бөгөөд эд хөрөнгийг нийлүүлж хадгалж буй нөхцөлд мөн адил байна 107.2.Агуулахын баримтад дараах зүйлийг заавал тусгана

	107.2.9.аюултай бараа байгаа тохиолдолд аюулын талаарх холбогдох мэдээлэл; 107.2.10.энэ хуулийн 106.4-т заасны дагуу хадгалж байгаа тохиолдолд энэ талаарх тэмдэглэгээ.
--	--

Арилжааны ерөнхий хууль дахь хуулийн этгээдийн үүрэгт холбогдох дараах зүйл, заалтыг (Хүснэгт 13-т заасан) хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцлоо.

Хүснэгт 13. Зардалд тооцсон үүрэг

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг /хэлцлийн баталгаат байдлыг хангах, маргаанаас урьдчилан сэргийлэх үүрэг /
Арилжаа эрхлэгч хуулийн этгээд	17.1.Үйлчлүүлэгч нь дараах үүрэгтэй байна: 17.1.2.арилжааны төлөөлөгчийн зуучилсан хэлцэл, эсхүл хэлцэл байгуулахад төлөөлөх бүрэн эрхгүйгээр байгуулсан хэлцлийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх талаар даруй мэдэгдэх; 17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх. 21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.
Арилжааны төлөөлөгч	16.1.Арилжааны төлөөлөгч нь дараах үүрэгтэй байна: 16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;
Арилжааны зуучлагч	28.1.Арилжааны зуучлагч өдөр бүр дэс дараатай тэмдэглэл хөтөлж, түүнд байгуулсан бүх хэлцлээ бүртгэж, цаасан хэлбэрээр үйлдсэн тохиолдолд тухай бүр гарын үсэг зурах, эсхүл цахим хэлбэрээр үйлдсэн тохиолдолд тоон гарын үсэг зурж баталгаажуулна. Тэмдэглэлийг цаг, минутын дарааллаар хөтөлнө. Тэмдэглэлд энэ хуулийн 22.3-т заасан баримтын агуулгыг тэмдэглэх үүрэгтэй.
Зорчигч тээвэрлэгч	89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

Барааны агуулахын үйлчилгээ үзүүлэгч	107.2.Агуулахын баримтад дараах зүйлийг заавал тусгана: 107.2.9.аюултай бараа байгаа тохиолдолд аюулын талаарх холбогдох мэдээлэл; 107.2.10.энэ хуулийн 106.4-т заасны дагуу хадгалж байгаа тохиолдолд энэ талаарх тэмдэглэгээ.
--------------------------------------	---

3.2 Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрд зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Хүснэгт 14. Стандарт үйл ажиллагааг тогтоох

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг /хэлцлийн баталгаат байдлыг хангах, маргаанаас урьдчилан сэргийлэх/	Стандарт үйл ажиллагаа
Арилжаа эрхлэгч хуулийн этгээд	17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.	Арилжааны төлөөлөгчийн байгуулсан гэрээний зөрчил бүрийг тухай бүр мэдэгдэх
	21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.	Арилжааны төлөөлөгчтэй үл өрсөлдөх талаар бичгээр гэрээ байгуулах

Арилжааны төлөөлөгч	16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;	Хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй мэдэгдэх
Зорчигч тээвэрлэгч	89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.	Зорчигчийн гар тээш, хадгалуулахаар зохих нэгжид хүргүүлэх

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Хүснэгт 15. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин¹⁰

	2023-II	2023-III	2023-IV
Аж ахуй нэгж байгууллагын сарын дундаж цалин	1,890 мянга мянган төгрөг	2,009.3 мянган төгрөг	2,235.4 мянган төгрөг

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн жилүүдэд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Сүүлийн гурван сарын дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг 2044.9 мянган төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

2,044,900 / 176 цаг = 11,618.7 төгрөг /цагт/

2,044,900 / 10560 минут = 193.6 төгрөг /мин/

¹⁰ Монгол Үндэсний

Статистик

(https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171320/table-view/DT_NSO_0400_023V1);

Хүснэгт 16. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг
цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг /хэлцийн баталгаат байдлыг хангах, маргаанаас урьдчилан сэргийлэх/	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Арилжаа эрхлэгч хуулийн этгээд	17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.	Арилжааны төлөөлөгчийн байгуулсан гэрээний зөрчил бүрийг тухай бүр мэдэгдэх	5	193.6	968
	21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.	Арилжааны төлөөлөгчтэй үл өрсөлдөх талаар бичгээр гэрээ байгуулах	30	193.6	5808
Арилжааны төлөөлөгч	16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;	Хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй мэдэгдэх	5	193.6	968
Зорчигч тээвэрлэгч	89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй	Зорчигчийн гар тээш, тээшийг хадгалуулахаар шилжүүлэх	10	193.6	1936

	бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.				
--	--	--	--	--	--

3.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

- Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
- Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Давтамжийн тоог тооцоолох боломжгүй тул хамгийн багадаа жилд 1 удаа гүйцэтгэнэ гэж үзэж тоон үзүүлэлтийг хэмжлээ. Мөн 1 арилжааны хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох зарчмыг баримталж тохиолдлын тоог 1 гэж үзэв.

Хүснэгт 17. Тоон үзүүлэлтийг тооцох

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг /хэлцлийн баталгаат байдлыг хангах, маргаанаас урьдчилан сэргийлэх/	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Арилжаа эрхлэгч хуулийн этгээд	17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.	Арилжааны төлөөлөгчийн байгуулсан гэрээний зөрчил бүрийг тухай бүр мэдэгдэх	1	1	1
	21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд	Арилжааны төлөөлөгчтэй үл өрсөлдөх талаар бичгээр гэрээ байгуулах	1	1	1

	тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.				
Арилжааны төлөөлөгч	16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;	Хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй мэдэгдэх	1	1	1
Зорчигч тээвэрлэгч	89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.	Зорчигчийн гар тээш, тээшийг хадгалуулахаар шилжүүлэх	1	1	1

3.4. Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт, өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 18. Нийт зардлыг тооцох

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг / хэлцлийн баталгаат байдлыг хангах, маргаанаас урьдчилан сэргийлэх /	Стандарт үйл ажиллагаа	Зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Арилжаа эрхлэгч	17.1.3.арилжааны төлөөлөгчийн	Арилжааны төлөөлөгчийн	968	1	968

хуулийн этгээд	зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.	байгуулсан гэрээний зөрчил бүрийг тухай бүр мэдэгдэх			
	21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.	Арилжааны төлөөлөгчтэй үл өрсөлдөх талаар бичгээр гэрээ байгуулах	5808	1	5808
Арилжааны төлөөлөгч	16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;	Хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй мэдэгдэх	968	1	968
Зорчигч тээвэрлэгч	89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.	Зорчигчийн гар тээш, тээшийг хадгалуулахаар шилжүүлэх	1,936	1	1,936

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд хуульд заасан нөхцөлд 1 удаа арилжаа эрхлэгч 1 хуулийн этгээдэд 6774 төгрөг, 1 арилжааны төлөөлөгчид 968 төгрөг, зорчигч тээвэрлэгчид 1936 төгрөгийн зардал нэмэлтээр үүсэхээр байна. Гэсэн хэдий ч, эдгээр зардал нь арилжаа эрхлэгчийн хэлцийн баталгаат байдлыг хангаж, хожим гарах маргаан, шүүхийн зардлаас урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Шигтгээ 4.

АРИЛЖААНЫ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЭЛЦЛИЙН БАТАЛГААТ БАЙДЛЫГ ХАНГАСНААР ХЭЛЦЛИЙН ХЭЛБЭР, ШҮҮХИЙН МАРГААН ЗЭРЭГ ЗАРЦУУЛАХ ҮР АШИГГҮЙ ЗАРДАЛ БУУРЧ, БИЗНЕСТЭЭ ЦАГ ХУГАЦАА, ХҮН ХҮЧЭЭ ТӨВЛӨРҮҮЛЭХ НЭМЭГДЭНЭ.

3.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

3.5.1. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;

Оролцогчдын тоог хамгийн багаар таамагласан тул хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй байна.

3.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Давтамжийг жилд 1 удаа гэж тооцсон тул багасгах боломжгүй.

3.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Мэдээллийн агуулгыг хуулийн төсөлд тусгайлан тусгаагүй байх тул зарцуулах хугацааг хамгийн багаар тооцсон болно.

3.5.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Арилжаа эрхлэгч, арилжааны төлөөлөгч нар хуульд заасан мэдэгдэх үүргээ гүйцэтгэхдээ цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой.

3.6. Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт, тус хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийн улмаас хуулийн этгээдэд бусад төрлийн нэмэлт зардал гарахгүй гэж тооцоолов.

IV. ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;

4.нийт дүнг тооцож гаргах;

5.хялбарчлах боломжийг шалгах.

4.1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Уг хуулийн төсөл хэрэгжсэнээр шууд иргэн буюу хэрэглэгчид үүсэх зардал байхгүй. Харин хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, хувиараа арилжаа эрхлэгч иргэнд нөлөөлөх зүйл заалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 19. Иргэний гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

	Хуулийн төсөл дэх иргэний гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
Хувиараа арилжаа эрхлэгч	6.7.Энэ хуулийн 6.4-т заасан арилжаа эрхлэгч нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлээгүй нь түүнийг арилжаа эрхлэгч биш гэж үзэх үндэслэл болохгүй. 6.11.Хувиараа арилжаа эрхлэгч нь орлого, зарлага, ашиг, алдагдал, өөрийн хөрөнгийн хэмжээг тооцоолох, хянах зорилгоор орлого, зарлагаа бүртгэж, бусдад худалдсан бараа, эсхүл үзүүлсэн үйлчилгээний орлого болон арилжааны үйл ажиллагаатай холбоотой зарлага гарсныг нотлох гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт зэргээр нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах үүрэг хүлээнэ. 10.1.Арилжааны бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр арилжаа эрхлэгч зохих өөрчлөлтийг арилжааны бүртгэлд	13.7.Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь тухайн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд шилжүүлэн авсан арилжааны үйл ажиллагаанаас нь үүссэн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээнэ. 13.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны нэрээ бусдад шилжүүлсэн хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ шилжүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд арилжааны нэрийг шилжүүлэн авсан этгээд арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг аймаг, нийслэлд ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

	тусгуулж, арилжааны бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй. Арилжааны бүртгэлд холбогдох өөрчлөлтөө тусгуулаагүйгээс гарах үр дагаврыг арилжаа эрхлэгч хариуцна. ▪ 13.3.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бичгээр байгуулж, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг зөрчсөн гэрээ хүчин төгөлдөр бус байна. ▪ 13.5.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад шилжүүлэх бол арилжааны үйл ажиллагаатай нь хамт, эсхүл өөрийн арилжааны үйл ажиллагааг бүрмөсөн зогсоосны дараа шилжүүлнэ. ▪ 13.8.Энэ хуулийн 13.7-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсны дараа даруй тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авахаас өмнө үүссэн үүргийг хариуцахгүй болохоо арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол тухайн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээхгүй. ▪ 13.9.Энэ хуулийн 13.6-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа шилжүүлэгч болон шилжүүлэн авагч нь гуравдагч этгээдэд хандан тухайн арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг шилжүүлэн авагч цаашид хариуцахгүй тухай мэдэгдсэн бол тухайн үүргийг	
--	---	--

	шилжүүлэн авагч гүйцэтгэх үүрэг хүлээхгүй. 14.6.Энэ хуулийн 14.2-т заасан арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь бусдад олгосон, эсхүл дуусгавар болгосон бол энэ талаар арилжааны бүртгэлд тухай бүр бүртгүүлэх үүрэгтэй.	
--	--	--

4.2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хувиараа арилжаа эрхлэгч иргэнд үүсэх ачааллыг тооцож гаргана. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжид заасны дагуу иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн (цаашид “үүрэг” гэх) тогтоох бөгөөд энэхүү аргачлалын 2.3-т заасныг баримтална.

Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцоход дараах аргачлалыг баримтална. Үүнд:

- иргэний гүйцэтгэх үүргийн агуулга, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэг бүрчлэн тодорхойлсны дараа уг үүргийг гүйцэтгэж зарцуулах цаг хугацааг шаардлагатай мөнгөн зардлын хамт тооцож гаргана.
- хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх хугацааг энэхүү аргачлалын 2 дугаар хавсралт болон 2.4.5-д заасан журмыг баримтлан тогтооно.
- мөнгөн зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал буюу бодит, тогтсон зардлыг тооцно. Үүнд: мэдээллийг холбогдох газарт хүргүүлэхэд гарах бичиг хэрэг, шуудангийн зардал, баримт бичгийг нотариатаар баталгаажуулахыг тухайлан шаардсан тохиолдолд нотариатын зардал, гадаад паспорт авах өргөдөл гаргахад цээж зураг авхуулах зардал, зөвшөөрөл хүсэхэд төлөх хураамж зэргийг оруулна. Ингэхдээ гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд тухайн иргэнээс гарч болох замын зардлыг тооцохгүй.

Хүснэгт 20. Зарцуулах хугацааг тооцох

	Гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
		Арилжааны нэрийн баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргах	10
		Баталсан маягтыг бөглөх	10

Хувиараа арилжаа эрхлэгч	Хувиараа эрхлэгчийн бүртгүүлэх арилжаа бүртгэлд	Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30
	Арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх	Баталсан маягтыг бөглөх	10
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх бүртгүүлэх	Арилжааны нэрийг ашиглуулах, шилжүүлэх гэрээг боловсруулах, байгуулах, баталгаажуулах	480
		Баталсан маягтыг бөглөх	10
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30
	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	2400

4.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх иргэний тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Дээрх чиг үүргийн тохиолдлын тоог тогтоох боломжгүй гэж үзэж, энэхүү зардлын тооцооны тайлангийн 1 дэх хэсэгт заасантай адилаар 1 гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, 1 удаагийн тохиолдолд зарцуулах хугацааг тооцов.

Давтамжийн тоо: Арилжааны ерөнхий хуулийн төсөлд хувиараа арилжаа эрхлэгчийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт өгөх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

Хүснэгт 21. Тоон үзүүлэлтийг тогтоох

	Гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Хувиараа арилжаа эрхлэгч	Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлэх	Арилжааны нэрийн баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргах	1	1	1
		Баталсан маягтыг бөглөх	1	1	1
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	1	1	1
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	1	1	1
	Арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх	Баталсан маягтыг бөглөх	1	1	1
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	1	1	1
		Хүсэлт, бүрдүүлэх	1	1	1

		материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах			
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх гэрээг бүртгүүлэх	Арилжааны нэрийг ашиглуулах, шилжүүлэх гэрээг боловсруулах, байгуулах, баталгаажуулах	1	1	1
		Баталсан маягтыг бөглөх	1	1	1
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	1	1	1
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	1	1	1
	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	1	1	1

4.4. Нийт дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт ачааллыг тооцно.

Хүснэгт 22. Иргэнд үүсэх ачааллыг тооцох

	Гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Тоон үзүүлэлт	Нийт ачаалал /минут/
Хувиараа арилжаа эрхлэгч	Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлэх	Арилжааны нэрийн баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргах	10	1	10
		Баталсан маягтыг бөглөх	10	1	10
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60	1	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30	1	30
	Арилжааны бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх	Баталсан маягтыг бөглөх	10	1	10
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60	1	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30	1	30
	Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх гэрээг бүртгүүлэх	Арилжааны нэрийг ашиглуулах, гэрээг шилжүүлэх боловсруулах, байгуулах, баталгаажуулах	480	1	480
		Баталсан маягтыг бөглөх	10	1	10
		Хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлэх	60	1	60
		Хүсэлт, бүрдүүлэх материалыг хүргүүлэх, хариуг хүлээн авах	30	1	30

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах	2400	1	2400
Иргэнд үзүүлэх ачаалал				3130 минут

Шигтгээ 5.

ХУВИАРАА АРИЛЖААНЫ ЭРХЛЭГЧИЙН СТАТУСЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ТҮҮНИЙ НЭР, ТӨЛӨӨЛӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ БҮРДҮҮЛСНЭЭР ТҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ НАЙДВАРТАЙ БАЙДАЛ, ИТГЭЛ НЭМЭГДЭЖ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗАХ ЗЭЭЛ НЬ ТЭЛЭХ НӨХЦӨЛ БҮРДЭНЭ.

4.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, иргэнд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Хуулийн төсөлд арилжааны бүртгэлд бүртгүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах давтамжийг заагаагүй тул аргачлалд заасныг үндэслэн 1 гэж тооцсон тул мэдээллийг хүргүүлэх давтамж, агуулгыг бууруулах боломжгүй.

Харин арилжааны бүртгэлд “цахимаар бүртгүүлэх” тохиолдолд хэрхэн баталгаажуулах асуудлыг шийдвэрлээгүй байх бөгөөд бүртгэл, маягт цахимаар бөглүүлсэн тохиолдолд тэдгээрийн агуулга нь энгийн, ойлгомжтой, хэт олон мэдээлэл шаардаагүй байхад чиглэсэн байх ёстойг анхаарах нь зүйтэй.

Тохиолдлын тоо болон давтамжийг багасгах боломжгүй гэж үзлээ.

Хувиараа арилжаа эрхлэгчид үзүүлэх ачааллаас гадна хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор тодорхой зардлууд шууд үүсэхийг мөн тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал:

1. Улсын тэмдэгтийн хураамж
2. Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх гэрээний загварыг боловсруулах үйлчилгээ авах зардал
3. Нягтлан бодох бүртгэл хөтлөх мэргэжлийн этгээд хөлслөх зардал гэх мэт.

Гэсэн хэдий ч, хувиараа арилжаа эрхлэгч иргэний улсын бүртгэлтэй холбоотой үүрэг диспозитив байх бөгөөд бүртгүүлээгүй тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг иргэний эрх зүйн хүрээнд зохицуулсан байна. Тухайлбал, хувиараа арилжаа эрхлэгч иргэн нь бүртгүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй нь эрх зүйн хариуцлагыг үүсгэхгүй боловч, түүнийг арилжаа эрхлэгч биш гэж үзэх үндэслэл болохгүй байхаар зохицуулжээ.

V ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ЗАРДАЛД ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Арилжааны ерөнхий хуулийн төсөл нь арилжаа, бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай, мэргэжлийн байдлыг хангах замаар арилжаа эрхлэгчийн үр ашиггүй зардлыг бууруулахад чиглэх бөгөөд түүний нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг хэлцлийн зардлын онолд тулгуурлан тайлбарлах нь зүйтэй. Хэлцлийн зардал (transaction cost)¹¹ гэдэг нь зах зээл дээр эдийн харилцаанд оролцоход гарах зардлыг хэлнэ. Тухайлбал, бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авахад зарцуулах хүчин чармайлт, хөдөлмөр, цаг хугацаа, хэлэлцээ зэргийг ойлгоно.

Энэхүү ойлголтыг 1989 онд АНУ-ын эдийн засагч Oliver Eaton Williamson гаргаж тавьсан¹². Тэрээр гүйлгээний зардлыг аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулахад гарах зардал хэмээн тодорхойлж, үйлдвэрлэлийн зардал болон гүйлгээний зардлыг хэмжих замаар бизнесийн стратегийг боловсруулдаг хэмээн үзсэн. Өөрөөр хэлбэл, гүйлгээний зардал нь бизнесийн үйл ажиллагааг зохион байгуулж, удирдахад хамгийн чухал хүчин зүйлийн нэг хэмээн хэлж болно.

Мөн 1992 онд АНУ-ын эдийн засагч North, Douglass нь гүйлгээний зардлыг ойлголтыг гүнзгийрүүлж¹³, гүйлгээний зардлыг бага түвшинд барих тогтолцоо нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг хэмээн дүгнэсэн байдаг¹⁴.

Энэ хүрээнд судлаачид гэрээний харилцаанд гарах гүйлгээний зардлыг дараах гурван түвшинд авч үздэг байна. Энэ нь гэрээ байгуулах этгээд, гэрээний зүйл буюу бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлоход чиглэсэн судалгааны зардлаас эхлээд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх тохиролцоход гарах зардал, гэрээний биелэлтийг хангахад гарах зардлыг багтаасан өргөн ойлголт юм.

Хүснэгт 22. Гэрээний харилцаанд гарах хэлцлийн зардал

Хэлцлийн зардал		
Судалгаа	Хэлэлцээ	Биелэлт
Гэрээний зүйлийг тодорхойл оход гарах зардал	Гэрээ байгуулах тохиролцооны хүрээнд гарах зардал	Гэрээний биелэлтийг хангахад гарах зардал

¹¹ Иргэний хуулийн 6.1. "Хуульд заасан үндэслэл, журмаар иргэний гүйлгээнээс хасагдаагүй, мөнгөөр үнэлж болох, эдийн болон эдийн бус баялаг иргэний эрх зүйн харилцааны объект байна" хэмээн заажээ. Энэхүү Иргэний хууль дахь иргэний гүйлгээ гэсэн нэр томъёонд үндэслэн гүйлгээний зардал хэмээн орчуулав.

¹² Transaction Cost Economics, 2 vols., co-edited with Scott E. Masten, (E. Elgar, 1995), The Economics of Transaction Costs, co-edited with Scott E. Masten, (E. Elgar, 1999).

¹³ Pessali, Huascar F "The rhetoric of Oliver Williamson's transaction cost economics". Journal of Institutional Economics 2 (1): 45, 65 (2006).

¹⁴ North, Douglass C. 1992. "Transaction costs, institutions, and economic performance." San Francisco, CA: ICS Press.

Жишээ:	Жишээ:	Жишээ:
– Мэдээлэл цуглуулах хугацаа, хөдөлмөр – Гэрээний зүйлийг тодорхойлох – Гэрээний талыг тодорхойлох	– Үнэ, бусад нөхцөлийн талаарх хэлэлцээ – Хууль зүйн магадалгаа буюу DD хийх зардал – Гэрээ байгуулах уулзалт	– Шилжүүлэг хийх зардал – Гэрээний зүйлийг шалгах – Гэрээний биелэлтийг хянах

Улмаар дээрх гурван төрлийн гүйлгээний зардлыг бага түвшинд барих нь арилжаа эрхлэгчийн үргүй зардлыг бууруулж, ашигт ажиллагаа нэмэгдүүлнэ. Энэ нь эцсийн дүндээ эдийн засгийн харилцаанд оролцогчдод эергээр нөлөөлж, эдийн засгийн өсөлттэй холбогддог байна.

Монгол Улсын хувьд арилжааны харилцааны хэлцлийн зардал өндөр байгаа талаар судлаачид авч үзсэн байдаг¹⁵. Тухайлбал, 1541 ЖДҮ—ийн хүрээнд хийсэн судалгаанаас үзвэл Үжиг дунд бизнес эрхлэгчид жилд 9 сая төгрөгийг буюу борлуулалтын орлогынхоо 4.4 хувийг төрийн байгууллагатай харилцах албан бус хэлцлийн зардалд зарцуулж байна... Хэлцлийн зардлын дийлэнх нь алдагдсан боломжийн өртөг буюу бизнес эрхлэгчийн үр ашиггүй зарцуулсан цаг хугацааны зардал байна. Мөн аж ахуйн нэгжийн хэмжээ жигжиг байх тусам хэлцлийн зардлын дарамт илүү их тулгардаг¹⁶ гэжээ.

Энэ хүрээнд Арилжааны ерөнхий хууль нь хэлцлийн зардал дотроос арилжааны эрхлэгчийн түргэн шуурхай байдлыг хангаж, ил тод байдлаар дамжуулан итгэлийг нэмэгдүүлэх замаар судалгааны зардал, хэлэлцээрийн зардлыг бууруулахад шууд чиглэдэг. Улмаар судалгааны зардал, хэлэлцээрийн зардал буурах нь шууд бусаар гэрээний биелэлтийг хангах зардал буурахад эерэг нөлөөг үзүүлнэ.

Ялангуяа, Арилжааны ерөнхий хууль дахь арилжааны нэрийн зохицуулалт, арилжааны төлөөллийн зохицуулалт, арилжааны бүртгэлийн зохицуулалт нь судалгааны зардал, хэлэлцээрийн зардлыг бууруулахад томоохон үүргийн гүйцэтгэнэ. Тухайлбал, хуулийн төсөл дэх арилжааны нэрийн хамгаалал нь гэрээний талыг тодорхойлох зардлыг бууруулах бөгөөд арилжааны нэрд итгэсэн шударга гуравдагч этгээдийг хамгаалах замаар арилжааны тогтвортой байдлыг хангана.

Мөн арилжааны төлөөллийн зохицуулалт нь арилжаа эрхлэгч чиг үүргийн дагуу гэрээ хэлцэл хийх, компанийг төлөөлөх боломжийг эрх бүхий албан тушаалтан, ажилтанд олгох боломжийг нээснээр гүйцэтгэх удирдлагын гэрээ хэлцлийг баталгаажуулахад гарах хүн хүч, цаг хугацаа, итгэмжлэл олгоход гарах хүн хүч, цаг

¹⁵ Монголбанк, Жигжиг, дунд үйлдвэрийн хэлцлийн зардлын судалгаа, 2014.

¹⁶ Монголбанк, Жигжиг, дунд үйлдвэрийн хэлцлийн зардлын судалгаа, 312, 2014.

хугацаа, бодит зардал хэмнэгдэг боломж бүрдэнэ. Үүнээс гадна арилжааны төлөөллийн гадаад илэрхийлэлд итгэсэн шударга гуравдагч этгээдийг хамгаалах замаар гэрээний нөгөө талын төлөөлөх бүрэн эрхийг шалгахад хамаарах судалгааны зардлыг бууруулна.

Түүнчлэн арилжааны бүртгэлийн зохицуулалт нь арилжаа эрхлэгч болон гэрээний нөгөө тал хоорондын итгэлийг нэмэгдүүлж, гэрээний талаа олох, таньж мэдэхэд зарцуулах судалгааны зардал багасна. Зах зээлийн харилцаа өргөжин тэлж, арилжаа эрхлэгч өргөн цар хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой болсон өнөө үед гуравдагч этгээдийн итгэж болохуйц, үнэн зөвд тооцогдох мэдээллийг агуулсан бүртгэлийн тогтолцоо нь чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү гүйлгээний зардлыг бууруулах хүрээнд хуулийн төсөлд Иргэний хуулийн 1.2-т заасан зарчмуудаас гадна арилжааны эрх зүйн онцлогийг тодотгосон дараах тусгайлсан зарчмууд мөрдөгдөхөөр тусгагдсан бөгөөд уг зарчмын хүрээнд хуулийн зүйл, заалт боловсруулагдсан болно¹⁷. Үүнд:

- Арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах

Тус зарчмын хүрээнд Иргэний хуулийн субъектээс ялгаатай нь арилжаа эрхлэгч нь нэгэнт ашиг олохыг зорьж байгаа этгээд тул бусдын төлөө хийсэн үйлдэлдээ хариу төлбөр шаардах эрхийг баталгаажуулсан. Тухайлбал, хуульд заасан хүү шаардах эрхийг тусгав.

Цаашлаад Иргэний хуульд ажил хэргийн хүрээнд тогтсон заншил, талуудын хооронд тогтсон практикийг хэрэглэж болохоор заасан боловч шүүхийн шийдвэрт судалгаа¹⁸ хийхэд маргааны талуудаас эдгээрийг нэхэмжлэл, хариу тайлбарын үндэслэлдээ дурдсан тохиолдол хэд хэд байгаа хэдий ч шүүгч түүнийг хэргийг хянан шийдвэрлэхдээ харгалзан үзээгүй бөгөөд шүүхийн шийдвэрт яагаад хэрэглээгүй гэдгээ тайлбарласан тохиолдол байхгүй байна. Үүнээс үзэхэд шүүгч хэрэг маргааны шийдвэрлэхдээ хуулиас бусад эрх зүйн эх сурвалжийг хэрэглэхээс зайлсхийх хандлагатай байна. Харин арилжааны эрх зүйд, ялангуяа хоёр талт арилжааны хэлцлийн хувьд мэргэшсэн арилжаа эрхлэгчдийн хоорондын харилцааг зөвхөн хуулиар бус гэрээгээрээ болон талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил буюу арилжааны заншлаараа илүү уян хатан зохицуулах боломжийг олгодог. Учир нь арилжаа эрхлэгчид нь иргэний эрх зүйн субъектээс илүү мэргэшсэн, хариуцлагатай субъект болохын хувьд өөрөө өөрсдийнхөө харилцаанд хэрэглэх хэм хэмжээгээ бүтээхийг тодорхой хэмжээнд зөвшөөрдгөөрөө иргэний эрх зүйгээс ялгардаг. Иймд талуудын хооронд тогтсон практик, арилжааны заншлыг арилжааны эрх зүйн нэгэн эх сурвалж болгож, шүүх эдгээр хэм хэмжээг хэрэглэхийг дэмжих үүднээс эдгээр нэр томъёог тодорхойлж, хууль хэрэглэх тухай зүйлд энэ талаар тусгасан.

- Гадаад нөхцөл байдалд үнэнч шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах

¹⁷ Арилжааны ерөнхий хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга.

¹⁸ Арилжааны заншил, тогтсон практикийн талаарх судалгаа. Уб. 2020. "Өмгөөлөл судлалын академи" ТББ.

Тус зарчмын хүрээнд арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх, арилжааны бүртгэлтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан. Тухайлбал, арилжаа эрхлэгчийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхад түүнийг тухайн хэлцлийг байгуулах, эсхүл бараа хүлээн авах, буцаах гэх мэт тодорхой үйлдлийг гүйцэтгэх эрхтэй эсэхийг заавал шалгах нь ажлыг удаашруулж хүндрэл үүсгэх тул түүнийг арилжаа эрхлэгчийг төлөөлөх бүрэн эрхтэй гэж тооцох зохицуулалт тусгасан. Түүнчлэн арилжаа эрхлэгч өөрийн арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах эрхийг хэн нэгэнд өгсөн боловч үл хөдлөх эд хөрөнгө захиран зарцуулах, барьцаа, баталгаа гэх мэт өөрт нь үүрэг үүсгэх хэлцэл хийх эрхийг олгоогүй бол энэ талаараа төлөөлөгч, төлөөлүүлэгч нар гуравдагч этгээдэд урьдчилж мэдэгдсэн тохиолдолд л эдгээр хязгаарлалт үүсэхээр буюу үүсэх үр дагавар, хариуцлагаас нь төлөөлүүлэгч чөлөөлөгдөхөөр заасан. Түүнчлэн арилжааны бүртгэлийг энэ зарчмыг хангах зорилгоор бий болгох бөгөөд арилжааны бүртгэлд оруулсан аливаа нээлттэй мэдээллийг гуравдагч этгээд үзэж, түүнийг үнэн зөв гэж итгэх итгэлийг нь баталгаажуулсан.

- Арилжаа эрхлэгч нь үүргээ биелүүлэхдээ мэргэшсэн, анхаарал болгоомжтой хандах

Уг зарчмын хүрээнд жишээ нь арилжаа эрхлэгч нь нэгэнт амласан буюу эрсдэлээ тооцсоны үндсэн дээр зөвшөөрч гэрээ байгуулсан тул өөрийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой төлөхөөр тохиролцсон анзыг багасгуулахаар Иргэний хуулийн субъектийн адил шаардах эрхгүй гэх мэт зохицуулалтууд тусгагдсан.

Иргэний хууль дахь дээрх төрлийн зохицуулалт тодорхой бус, практикт харилцан адилгүй тайлбарлан хэрэглэдэг нь энэ төрлийн харилцааны оролцогчдод ихээхэн хүндрэл учруулахаас гадна талуудын хооронд үүссэн маргаан даамжирч шүүхийн олон шат дамжлагаар шийдвэрлэгдэх нь бий.

Дээр дурдсан гүйлгээний зардлын онолд тулгуурлан, Арилжааны ерөнхий хуулийн төсөл дэх үндсэн өөрчлөлтүүдтэй холбоотойгоор төр, хуулийн этгээд, иргэнд хэмнэгдэх зардал тус бүрийг доорх хэсгүүдэд тооцлоо. Ингэхдээ гагцхүү тооцох боломжтой эерэг нөлөөллийг тооцсон болно. Өөрөөр хэлбэл, тооцох боломжгүй эсхүл тооцоход хүндрэлтэй олон төрлийн эерэг нөлөөлөл гарах нь зайлшгүй.

5.1. Хуулийн этгээдэд үзүүлэх эерэг нөлөөлөл

Хуулийн этгээдэд үзүүлэх нөлөөг тодорхой тохиолдлыг хийсвэрлэх замаар дор үзүүлэв.

Кейс 1. “А” компани нь “Д” компанийн дэд захиралтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, холбогдох ажлыг хүлээлгэн өгч, “Д” компани гэрээний төлбөрийн хагасыг төлсөн. “Д” компанийг төлөөлж гэрээг компанийн дэд захирал байгуулсан. Гэрээнд заасан хугацаа өнгөрснөөс 1 сарын дараа “А” компани “Д” компаниас ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл төлбөр болох 50 сая төгрөгийг шаардсан бол, “Д” компани тус ажил гүйцэтгэх гэрээг компанийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд байгуулсан гэдэг үндэслэлээр татгалзсан байна. Иймд “А” компани 5 сая төгрөгийн үнэ бүхий өмгөөлөгч хөлсөлж шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Талууд 3 шатны шүүхээр маргаанаа шийдвэрлүүлсэн бөгөөд нийтдээ 1.5 жилийн хугацаа зарцуулсан.

Дээрх тохиолдолд Арилжааны ерөнхий хуульд тусгагдсан арилжааны бүртгэл, арилжааны төлөөллийн зарчим үйлчилснээр дараах цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.



Кейс 1-ийн хувьд харьцангуй хийсвэр, тохиолдох магадлал бага тул хуулийн этгээдүүдийн гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах, төлбөр биелэлтийг хангуулах зорилгоор гүйцэтгэж буй нийтлэг үйл ажиллагааг тодорхойлж, түүнд зарцуулах хугацаа, зардлыг тооцов. Арилжааны ерөнхий хууль батлагдсанаар уг хугацаа, зардлыг хэмнэнэ гэж үзэж байна.

Цаашлаад 1 удаагийн хэлцлийн үед 1 арилжааны хуулийн этгээдээс гэрээний хүчин байдлыг баталгаажуулах, төлбөрийн гүйцэтгэлийг хангуулахад чиглэн гүйцэтгэж буй стандарт үйл ажиллагааны хүрээнд хэмнэгдэх хугацаа болон холбогдох шууд бус зардлыг дор тооцлоо.

Хүснэгт 23. Хуулийн этгээдийн хэмнэх зардал

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Хэмнэгдэх хугацаа	Ажлын хөлс	Зардал
Хуулийн этгээд	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	480	193.6	92928
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	120	193.6	23232

		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	240	193.6	46464
		Эрх шилжүүлэх тушаал, журам батлах, шинэчлэх хүрээнд	4080	193.6	789888
	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	480	193.6	92928
		Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	4080 ¹⁹	193.6	789888

Хүснэгт 24. Тоон үзүүлэлтийг тогтоох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо ²⁰	Давтамж ²¹	Тоон үзүүлэлт
Хуулийн этгээд	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	1	1	1
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	1	1	1

¹⁹ Нэхэмжлэл бэлдэх, хянах, баталгаажуулах, итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах, шүүхэд нэхэмжлэлээ хүргэх, хэрэг үүсгэсэн талаар лавлах, хурлын товыг асуух, хуралд оролцох, хуралд хойшлогдсон тохиолдолд дахин хуралд оролцох, шүүхийн шийдвэрийг гардан авах, төлбөрийг сайн дураар төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргах бол түүнийг боловсруулах, баталгаажуулах, шүүхэд хүргэж өгөх, албадан гүйцэтгүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүсэлт боловсруулах, хүргүүлэх гэх мэт стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамгийн багадаа 14 хоног буюу 4080 минут зарцуулна гэж үзлээ.

²⁰ 1 хуулийн этгээдийн хувьд хэмнэгдэх зардлыг тооцох тул тохиолдлын тоог 1 гэж үзлээ.

²¹ Тасралтгүй үргэлжлэх шинжтэй тул 1 гэж үзлээ.

		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	1	1	1
		Эрх шилжүүлэх тушаал, журам батлах, шинэчлэх хүрээнд	1	1	1
	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	1	1	1
		Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	1	1	1

Хүснэгт 25. Хэмнэгдэх нийт зардлыг тооцох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Зардал	Нийт зардал
Хуулийн этгээд	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	1	92928	92928
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	1	23232	23232
		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	1	46464	46464

		Эрх шилжүүлэх тушаал, журам батлах, шинэчлэх хүрээнд	1	789888	789888
	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	1	92928	92928
		Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	1	789888	789888
	Нийт				

1 удаагийн хэлцлийн үед 1 арилжаа эрхлэгч хуулийн этгээдээс гэрээний хүчин байдлыг баталгаажуулах, төлбөрийн гүйцэтгэлийг хангуулахад чиглэн гүйцэтгэж буй стандарт үйл ажиллагааны хүрээнд хэмнэгдэх шууд бус зардал нь **1,835,328.00 төгрөг байна. Уг үзүүлэлтийг одоо үйл ажиллагаа явуулж буй** 81621 арилжааны хуулийн этгээдийн тоонд үржүүлж үзвэл 149,801,306,688.00 төгрөг гэсэн дүн гарна.

5.2. Иргэнд үзүүлэх эерэг нөлөөлөл²²

Иргэн үзүүлэх эерэг нөлөөг тодорхой тохиолдлыг хийсвэрлэх замаар дор үзүүлэв.

Кейс 2. Иргэн Х өөрийн зуслангийн байшиндаа гал тогооны тавилга хийлгэх сонирхолтой байгаагаа найз Д-дээ хэлэхэд, Д түүнд хувиараа тавилга үйлдвэрлэдэг хэд хэдэн арилжаа эрхлэгчийн талаар мэдээлэл өгөв. Гэвч тус иргэдийн хариуцлагатай, найдвартай, мэргэжлийн байдлын талаар хангалттай мэдээлэлгүй тул шийдвэр гаргаж чадалгүй, интернэтээр 2 өдөр судалсны эцэст найз Д-ын өмнө нь үйлчлүүлсэн “Модон тавилга” гэх фэйсбүүкийн хаягаар нэгэн хувиараа арилжаа эрхлэгчтэй холбогдож, харилцан тохиролцож урьдчилгаа 3 сая төгрөгөө шилжүүлсэн. Гэвч “Модон тавилга” тохирсон хугацаанд тавилгыг хийж өгөөгүй тул өмгөөлөгчийн хөлсөнд 2 сая төгрөг өгч, шүүхэд хандаж, хэргийг 3 сарын дотор шүүхээр шийдвэрлэсэн боловч хариуцагч иргэн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй байна. “Модон тавилга” гэх фэйсбүүк хуудсыг жинхэнэ арилжаа эрхлэгч нь 1 жилийн өмнөөс хөтлөхөө больж, уг хуудсаа хариуцагч иргэнд зарсан боловч тухайн этгээд “Модон тавилга” гэх нэрийг ашиглан удаа дараа бусдыг залилсныг Х сүүлд мэджээ.

²² Энэхүү зардлын тооцооны хүрээнд “иргэн” гэдэгт “хувиараа арилжаа эрхлэгч”-ийг ойлгож байна.

Дээрх тохиолдолд арилжааны бүртгэлийн ач холбогдол чухлаар хөндөгдөх бөгөөд хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэл бүртгүүлсэн байсан тохиолдолд иргэн opendata-д нэвтрэх байдлаар нягтлах боломжтой тул Х хохирохгүйгээр дараах зардлыг хэмнэх боломжтой үзэж болно.



Кейс 2-ийн хувьд харьцангуй хийсвэр, тохиолдох магадлал бага тул иргэн, хувиараа арилжаа эрхлэгчдийн гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах, төлбөр биелэлтийг хангуулах зорилгоор гүйцэтгэж буй нийтлэг үйл ажиллагааг тодорхойлж, түүнд зарцуулах хугацаа, зардлыг тооцов.

Арилжааны ерөнхий хууль батлагдсанаар уг хугацаа, зардлыг хэмнэнэ гэж үзэж байна.

Хүснэгт 26. Хэмнэх хугацааг тооцох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
Хувиараа арилжаа эрхлэгч	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	480
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	120
		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	240

	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	480
		Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	4080 ²³

Хүснэгт 27. Тоон үзүүлэлтийг тогтоох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо ²⁴	Давтамж ²⁵	Тоон үзүүлэлт
Хувиараа арилжаа эрхлэгч	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	1	1	1
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	1	1	1
		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	1	1	1
	Төлбөрийн биелэлтийг	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	1	1	1

²³ Нэхэмжлэл бэлдэх, хянах, баталгаажуулах, итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах, шүүхэд нэхэмжлэлээ хүргэх, хэрэг үүсгэсэн талаар лавлах, хурлын товыг асуух, хуралд оролцох, хуралд хойшлогдсон тохиолдолд дахин хуралд оролцох, шүүхийн шийдвэрийг гардан авах, төлбөрийг сайн дураар төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргах бол түүнийг боловсруулах, баталгаажуулах, шүүхэд хүргэж өгөх, албадан гүйцэтгүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүсэлт боловсруулах, хүргүүлэх гэх мэт стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамгийн багадаа 14 хоног буюу 4080 минут зарцуулна гэж үзлээ.

²⁴ 1 арилжаа эрхлэгч хувь хүний зарцуулах хугацааг тооцох тул тохиолдлын тоог 1 гэж үзэв.

²⁵ Тасралтгүй үргэлжлэх шинжтэй тул 1 гэж үзлээ.

	хангуулах, зөрчлийг арилгуулах	Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	1	1	1
--	--------------------------------------	--	---	---	---

Хүснэгт 28. Нийт бууруулах ачааллыг тооцох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Хугацаа	Нийт ачаалал
Хуулийн этгээд	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Хэлцэл хийгч талын мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хянах, шалгах хүрээнд	1	480	480
		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг баталгаажуулах хүрээнд	1	120	120
		Итгэмжлэл үйлдэх, нотариатаар баталгаажуулах хүрээнд	1	240	240
	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Гэрээнд холбогдох аливаа аргыг тусгах, хянах, харилцан тохиролцох хүрээнд	1	480	480
		Төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол шүүхэд хандах, шийдвэрлүүлэх хүрээнд	1	4080	4080
Нийт хэмнэгдэх хугацаа					5400минут

5.3 Төрд үзүүлэх эерэг нөлөөлөл

Төрд үзүүлэх эерэг нөлөөллийг тогтоохын тулд юун түрүүнд арилжааны маргаантай холбоотойгоор төрийн байгууллагад хэр хэмжээний ачаалал үүсдэгийг тодруулна. Энэ хүрээнд Арилжааны ерөнхий хуулийн төсөл нь арилжаа эрхлэгчийн хэлцлийн баталгаат байдлыг сайжруулах замаар шүүхийн маргаанаас урьдчилан сэргийлэх, зардлыг бууруулах, худалдаан арилжааны харилцааны итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэжээ.

Шигтгээ 5.

АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ НЬ ХЭЛЦЛИЙН БАТАЛГААТ БАЙДЛЫГ САЙЖРУУЛЖ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ ЗАМААР МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, ШҮҮХИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛНА.

Шүүхээр шийдвэрлэгдэж буй иргэний хэргийн статистикийг авч үзвэл:

Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 60 орчим хувь нь иргэний эрх зүйн маргаан байх бөгөөд түүнд эзлэх арилжааны эрх зүйн маргааны хувь хэмжээг тусгайлан гаргаагүй байна. Гэвч 2018 оны статистикаар арилжааны гэрээний маргаан нийт иргэний эрх зүйн маргааны 21 хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 29 . Анхан шатны шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг

Үзүүлэлт	2021	2022	2023	Дундаж
Иргэний хэрэг	46,291	57633	46,291	50,072
Иргэний эрх зүйн маргаан (Иргэний хэргийн 60 хувь)	27775	34580	27775	30,043
Арилжааны гэрээний маргаан (Иргэний эрх зүйн маргааны 21 хувь)	5833	7262	5833	6,309

Хүснэгт 30 . Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг

Үзүүлэлт	2021	2022	2023	Дундаж
Иргэний хэрэг	2,573	3,048	3,110	2,910
Иргэний эрх зүйн маргаан (Иргэний хэргийн 60 хувь)	1544	1829	1866	1,746
Арилжааны гэрээний маргаан (Иргэний эрх зүйн маргааны 21 хувь)	324	384	392	367

Хүснэгт 31. Улсын дээд шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг

Үзүүлэлт	2021	2022	2023	Дундаж
Иргэний хэрэг	1948	2680	1776	2,135
Иргэний эрх зүйн маргаан (Иргэний хэргийн 60 хувь)	1169	1608	1066	1,281
Арилжааны гэрээний маргаан (Иргэний эрх зүйн маргааны 21 хувь)	245	338	224	269

Арилжааны гэрээний эрх зүйн маргаан нь дараах төрөлтэй. Үүнд:

1. Гэрээ хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой маргаан
2. Төлбөрийн зөрчилтэй холбоотой буюу үндсэн үүргийн гүйцэтгэлийг шаардах
3. Доголдолтой холбоотой шаардах эрх хэрэгжүүлэх
4. Үүргийн зөрчил эсхүл хугацаа хэтрүүлснээс учирсан хохирол шаардах
5. Үүргийн зөрчлийн улмаас гэрээнээс татгалзах, түүнд холбогдох хохирол шаардах, өгсөн авснаа буцаах зэрэг.

Арилжааны гэрээний эрх зүйн маргааны төрөл, шаардах эрхийн үндэслэлийг гаргасан статистик байхгүй байх тул дээр заасан маргаан тус бүр арилжааны гэрээний маргааны 20 хувийг эзэлдэг гэж үзэж, тохиолдлын тоог тогтоов.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гаргасан 2022 оны мэдээнд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэх нийт 39,691 шүүх хуралдаан зарласнаас 21,619 буюу 54,4 хувь нь хойшилжээ. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хугацаа хамгийн уртдаа 16.6 жил байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 30-120 хоног гэв.²⁶

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүд нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт 189210 гүйцэтгэх хуудасны 7.998.353.658.9 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 39355 гүйцэтгэх хуудасны 4.631.379.317.3 төгрөгийн төлбөрөөс 18183 гүйцэтгэх хуудасны 702.330.962.2 төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт 39415 гүйцэтгэх хуудасны 1.504.141.175.6 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 8425 (**21.3 хувь**) гүйцэтгэх хуудасны 872.329.320.5 төгрөгийн төлбөрөөс тус онд 4004 гүйцэтгэх хуудасны 175.662.981.8 төгрөг;
- 2018 онд нийт 38493 гүйцэтгэх хуудасны 1.853.072.717.6 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 8269 (**21.4 хувь**) гүйцэтгэх хуудасны 1.208.248.849.8 төгрөгийн төлбөрөөс тус онд 4265 гүйцэтгэх хуудасны 246.406.724.3 төгрөг;
- 2019 онд нийт 44663 гүйцэтгэх хуудасны 2.534.369.306.5 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 8736 (**19.5 хувь**) гүйцэтгэх хуудасны 1.131.189.772.2 төгрөгийн төлбөрөөс тус онд 4494 гүйцэтгэх хуудасны 147.182.243.7 төгрөг;
- 2020 онд нийт 39327 гүйцэтгэх хуудасны 467.626.125.3 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 8331 (**21.1 хувь**) гүйцэтгэх хуудасны 270.760.262.2 төгрөгийн төлбөрөөс тус онд 4245 гүйцэтгэх хуудасны 64.946.685.7 төгрөг;
- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт 27312 гүйцэтгэх хуудасны 1.639.144.333.9 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 5594 гүйцэтгэх хуудасны 1.148.851.112.6 төгрөгийн төлбөрөөс тус онд 1175 гүйцэтгэх хуудасны 68.132.326.7 төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Нийт хуулийн этгээдийн 80 гаруй хувийг компани, нөхөрлөл гэх аж ахуй нэгж эзэлдэг тул хуулийн этгээдэд холбогдох шийдвэр гүйцэтгэлийн хуудасны 80 хувийг тогтоож, түүний 21 хувийг арилжааны гэрээний маргаанд холбоотой тохиолдлын тоо гэж, түүний 20 хувийг аль нэг төрлийн арилжааны гэрээний маргаанд холбогдох тоо гэж үзлээ.

²⁶ https://www.judcouncil.mn/site/news_full/13461

ШШГЕГ-ын мэдээгээр сүүлийн 5 жилийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээнээс харахад жил бүр ойролцоогоор 1 их наяд төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг биелэгддэггүй байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 39667 гүйцэтгэх баримт бичгийн 2.7 их наяд төгрөгийг биелүүлэхээс 16511 гүйцэтгэх баримт бичгийн 522.8 тэрбум төгрөгийг биелүүлж, 23156 гүйцэтгэх баримт бичгийн 2.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлт 41.6 хувь, мөнгөн дүн 19.4 хувьтай гарсан байна. Эндээс үзвэл иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл тодорхойгүй хугацаагаар удаашрах магадлал маш өндөр байна. Өөрөөр хэлбэл, талуудын хэрэглэх хуулийг тодорхой болгох нь талуудын хооронд үүсэх маргааныг бууруулах, шүүхээр шийдвэрлэгдэх тус төрлийн маргааны тоог бууруулах, шүүхээр шийдвэрлэх хугацааг бууруулах, улмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачааллыг бууруулж, бусад гүйцэтгэх ажиллагааны чанарыг сайжруулах эерэг нөлөөтэй байна.

Хүснэгт 29. Хүний нөөцөд үүсгэж буй ачааллыг тооцох

	Зорилго	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцөд үүсгэж буй ачаалал /минут/
Төрийн байгууллага	Гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах	Зохицуулагч байгууллагаас гэрээнд тавигдах стандартыг боловсруулах батлах, шинэчлэх	2400 ²⁷	1	2400
		Зохицуулагч байгууллага өргөдөл, гомдлыг	9600 ²⁹	139	1334400

²⁷ Ажлын хэсэг байгуулах, хуралдах, төслийг боловсруулах, сайжруулах, хянах, батлах бүхий л үе шатанд нийт 2400 минут буюу ажлын 5 хоног зарцуулна гэж үзэв.

²⁹ Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргах тухай хуулийн дагуу нэг гомдлыг шийдвэрлэх хугацаа 1 сар буюу ажлын 22 хоног хэдий ч дээрх төрлийн гомдлыг ажлын 10 хоногт шийдвэрлэнэ гэж бууруулж тооцлоо.

		хүлээн авах шийдвэрлэх ²⁸			
		Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх	14,400 ³⁰	1261	18158400
		Давж заалдах шатны шүүх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	14,400	73	1051200
		Улсын дээд шүүх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	14,400	53	763200
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх, биелүүлэх	9600 ³¹	270	2592000
	Төлбөрийн биелэлтийг хангуулах, зөрчлийг арилгуулах	Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх	14,400	1261	18158400
		Давж заалдах шатны шүүх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	14,400	73	1051200

²⁸ Санхүүгийн зохицуулах хороонд 2023 онд нийт 1,138 өргөдөл, гомдол ирүүлсний албан бичгээр буюу цаасаар 719, цахимаар 383, 11-11 төвөөр 36 болно. Нийт өргөдөл, гомдлын 575 нь даатгал, 250 нь ББСБ, 144 нь үнэт цаас, 18 нь ХЗХ, 151 нь бусад чиглэлээр ирсэн байна.

2022 онд цаасаар болон цахимаар нийт 599 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр буюу цаасаар 443, цахимаар 156 өргөдөл, гомдол хянан шийдвэрлэсэн. Нийт өргөдөл, гомдлын 238 нь даатгал, 136 нь ББСБ, 128 нь үнэт цаас, 20 нь ХЗХ, 77 нь бусад чиглэлээр ирсэн байна.

2021 онд цаасаар болон цахимаар нийт 699 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр буюу цаасаар нийт 475 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч тайлант хугацаанд 454 өргөдлийг шийдвэрлэсэн.

Дээрх үзүүлэлтээс үзэхэд жилд дунджаар 697 гомдлыг шийдвэрлэдэг байна. Арилжааны гэрээтэй холбоотой шаардлага үндсэн 5 төрөлтэй гэж үзсэн тул дээрх үзүүлэлтийн 20 хувийг нэг төрлийн шаардах эрхтэй холбоотой маргааны тохиолдлын тоо гэж үзэв.

³⁰ Өмнө дурдсан статистикаар 1 иргэний хэргийг хамгийн багадаа 30 хоногт шийдвэрлэх тул ажлын 30 хоногоор тооцлоо.

³¹ Хэдийгээр шийдвэр гүйцэтгэлийн хувь бага ч шийдвэр гүйцэтгэгчээс тухайн нэг гүйцэтгэх хуудаст зарцуулах хугацааг жилийн туршид ажлын 10 хоног гэж бууруулан тооцлоо.

		Улсын дээд шүүх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	14,400	53	763200
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх, биелүүлэх	9600	270	2592000
Нийт				46.466.400 минут	

VI ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд хийх зардлын тооцоо нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой болно. Үүний хүрээнд Арилжааны ерөнхий хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан тооцов.

Мөн Арилжааны ерөнхий хуулийн төсөл нь арилжаа эрхлэгчийн хэлцлийн баталгаат байдлыг хангах замаар арилжааны үйл ажиллагааны хүрээнд гарах үр ашиггүй зардлыг бууруулахад чиглэжээ. Улмаар Арилжааны хуулийн төслийн үр дүнд үүсэх санхүүгийн болон санхүүгийн бус өгөөжийг хуулийн төсөл батлагдахаас өмнө үетэй харьцуулах замаар үнэлэв.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Хуулийн төслийг авч үзвэл, арилжааны бүртгэлийн хэвийн тогтвортой байдлыг хангахад улсын бүртгэлийн байгууллага өөрийн чиг үүргийн дагуу уг харилцаанд оролцож болохоор байна. Улмаар зардлын тооцооны хүрээнд арилжааны бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газар гүйцэтгэнэ гэж үзэв. Цаашлаад одоо байгаа хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой чиг үүргийг давхардуулан тооцолгүй гагцхүү хувиараа арилжаа эрхлэгчийг арилжааны бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой зардлыг тооцохыг зорилоо.

Тус байгууллагад хувиараа арилжаа эрхлэгчээс ирэх хүсэлтийн тоог урьдаас таамаглах боломжгүй байгаа тул аргачлалын дагуу тохиолдлын тоог 1 гэж үзэхэд, хувиараа арилжаа эрхлэгчээс ирүүлсэн нэг хүсэлтийг шийдвэрлэхэд хүсэлтийн төрлөөс хамааран 145-155 минут зарцуулах төлөвтэй байна. Жилд нийт 1000 хувиараа арилжаа эрхлэгч бүртгүүлнэ гэж үзвэл 105,427,530.52 төгрөгийн зардал тус тус төрд үүсэхээр байна.

Харин арилжааны бүртгэлийн чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллага/ХАҮТ гэх мэт/ар хэрэгжүүлэх практик бусад улсад байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ тохиолдолд төрд зардал үүсэхгүйгээс гадна хуулийн төслийн үр дүнд нийгэм, эдийн засгийн хүрээнд буурах зардлын хэмжээтэй харьцуулахад харьцангуй бага гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Хэдийгээр хуулийн төсөлтэй холбоотойгоор тодорхой хэмжээний зардал төрд үүсэх боловч, арилжаа эрхлэгчийн хувиар эрх зүйн харилцаанд оролцож, эрх зүйн хамгаалалтыг эдэлж чадахгүй байгаа хувиараа арилжаа эрхлэгчийн хэлцлийн баталгаат байдал, бусад эрх зүйн хамгаалал зэрэг давуу талуудтай харьцуулахад зардлын хувьд эерэг нөлөө үзүүлж, улмаар зохицуулах байгууллага, шүүхийн ачааллыг бууруулна гэж үзлээ.

Хоёр. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн салбар боловч Иргэний эрх зүйгээс ялгарах зарим онцлог зарчимтай байдаг. Арилжааны ерөнхий хууль дахь хэм хэмжээ нь дийлэнхдээ димпозитив шинжтэй байх тул гагцхүү зайлшгүй биелэгдэх шинжтэй буюу

императив хэм хэмжээгээр үүрэг хүлээлгэсэн зүйл, заалтыг сонгож, тэдгээрт холбогдох зардлыг тооцсон. Ийнхүү гэрээний талуудын эрх, зарчимтай холбогдох өөрчлөлтийг зардлын тооцооноос хасаж, гагцхүү императив заалт эсхүл голлох өөрчлөлттэй холбоотой зардлыг тооцож үзэхэд уг хуулийн төсөл хэрэгжсэнээр тус хуульд заасан урьдач нөхцөл бүрдсэн нөхцөлд 1 удаа 1 хуулийн этгээдэд 6774 төгрөг, 1 арилжааны төлөөлөгчид 968 төгрөг, 1 зорчигч тээвэрлэгчид 1936 төгрөгийн зардал учирна.

Нөгөө талаас арилжаа эрхлэгчдийн 1 удаагийн хэлцлийн үед 1 арилжаа эрхлэгч хуулийн этгээдээс гэрээний хүчин байдлыг баталгаажуулах, төлбөрийн гүйцэтгэлийг хангуулахад хэмнэгдэх шууд бус зардал нь 1,835,328.00 төгрөгийг хэмнэнэ. Эндээс үзвэл Арилжааны ерөнхий хууль нь арилжааны хуулийн этгээдийн цаг хугацаа, зардлыг хэмжээгээр хэмнэхээр байна.

Гурав. Иргэнд үзүүлэх ачааллыг тооцоо

Өмнө дурдсанаар Арилжааны ерөнхий хууль батлагдсанаар хувиараа арилжаа эрхлэгч иргэний арилжааны бүртгэлд бүртгүүлэх, үнэн зөв байдлыг хариуцах, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийлгэх, арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх тохиолдолд бүртгүүлэх зэрэг голлох үүргийг хүлээнэ. Дээрх үүргүүдтэй холбоотойгоор тухайлбал арилжааны бүртгэлд бүртгүүлэхэд дунджаар 170 минут, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахад 160 минут, нягтлан бодох бүртгэл хөтлөхөд 2400 минут, арилжааны нэрийг бусдад шилжүүлэхэд 580 минутын ачаалал үүснэ. Ийнхүү ачаалал үүсэх болсон шалтгаан нь санхүүгийн тайлан гаргах, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй холбоотой хэмээн ойлгож болно.

Иргэнд учрах ачааллыг бууруулах зорилгоор цахим арилжааны бүртгэлийг үүсгэх, идэвхжүүлэх, бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг багасгах, гэрээ, баримт бичгийн төслийн жишиг загвар гаргах зэрэг оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Нөгөөтээгүүр арилжааны бүртгэлд бүртгүүлснээр арилжааны харилцаанд орох сонирхол бүхий этгээдээс харахад тухайн арилжаа эрхлэгчийн найдвартай, мэргэжлийн, хариуцлагатай байдал нэмэгдэж, зах зээлд түүний өрсөлдөх чадвар сайжрах давуу талтай.

Дөрөв. Зардал-үр өгөөжийн үнэлгээ

Арилжааны ерөнхий хуулийн төсөл батлагдсанаар түүнийг дагалдан зардал гарах боловч нийт арилжаа эрхлэгчдэд үзүүлэх хуулийн төслийн үр өгөөж нь эерэг байх тул зардлыг зөвшөөрөгдөх хэмжээнд байна гэж дүгнэв.

Хуулийн төслийн үр өгөөжийг санхүүгийн болон санхүүгийн бус өгөөж хэмээн ангилж болохоор байна. Ялангуяа, Арилжааны ерөнхий хуулийн санхүүгийн бус өгөөж өндөр хэмээн дүгнэж болно. Энэ төрлийн өгөөжид иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагын ачаалал буурах, тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааг хялбарчлах зэргийн улмаас хэмнэгдэх цаг хугацаа, хөдөлмөр, хичээл зүтгэл болон нийгэм, эдийн засагт үзүүлэх бүхий л төрлийн эерэг нөлөөлөл хамаарна.

Цаашлаад хуулийн төсөл дэх арилжааны бүртгэл, арилжааны төлөөлөл зэрэг **арилжааны харилцааг түргэн шуурхай байлгах, хэлцлийн баталгаат байдлыг хангахад чиглэсэн тусгай зохицуулалт нь арилжаа эрхлэгчийн дотоод хэлцлийн**

зардлыг багасахаас гадна гэрээний хүчин төгөлдөр байдалтай холбоотой шүүхийн маргааны тоог бууруулж, улмаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг бодитой бууруулахаар байна.

Дээрхтэй холбоотой санхүүгийн өгөөжийг *шүүхийн* болон *шүүхийн бус* гэж ангилж үзвэл, тус хуулийн төсөл хэрэгжсэнээр зохицуулагч байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачааллыг 46,466,400 минутаар бууруулах боломжтойгоос гадна шүүхэд маргаан үүсгэх, өмгөөлөгч авах, шүүхэд тайлбар, нэхэмжлэл, нотлох баримт гаргаж өгөх, шүүх хуралдаанд оролцох зэрэгтэй холбоотойгоор арилжаа эрхлэгчид учрах *шүүхийн зардлыг* мөн бууруулна.

Харин *шүүхийн бус зардалд* тухайлан авч үзвэл, B2B, B2C харилцааны явцад хэлцлийн нэг тал хэлцэл хийгч нөгөө талын гэрээ байгуулах эрхтэй этгээдийн талаарх мэдээллийг цуглуулах, түүний төлөөлөх бүрэн эрхийн үндэслэл, итгэмжлэлийг хянах, дүн шинжилгээ хийх, танилцуулахад дунджаар 8 цаг буюу 1 ажлын өдрийг, хууль буюу итгэмжлэлээр төлөөлөх эрхтэй этгээдээр гэрээг заавал баталгаажуулахад дунджаар 2 цагийг зарцуулдаг гэж үзвэл нэг арилжаа эрхлэгч нэг удаагийн хэлцэл хийхэд ойролцоогоор 116,160 төгрөгийн зардалтай ажилладаг байна.

Арилжаа ерөнхий хуульд заасан арилжааны бүртгэл, төлөөлөлтэй холбоотой тусгай зарчим хэрэгжиж эхэлснээр дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх 1 тохиолдлын хүрээнд 81.6 мянга гаруй арилжааны хуулийн этгээдэд учрах зардал болох 9 тэрбум 400 гаруй сая төгрөгийг хэмнэх боломжтой. Цаашлаад гэрээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах, төлбөрийн гүйцэтгэлийг хангуулах хүрээнд 1 иргэний зарцуулах 5400 минутыг хэмнэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар “Арилжаа эрхлэгч” жинхэнэ үтгээр бизнесийн үйл ажиллагаандаа цаг зав, хүн хүчээ бүрэн зарцуулах боломж бүрдэнэ.